MMINFO

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,141.579.. ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.05.08. Даваа. №091 (4705) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




УЛС ТӨР

2017 ОН ГАРСНААР 1028 ИРГЭН ИПОТЕКИЙН ЗЭЭЛД ХАМРАГДЖЭЭ

II нүүрт

ДЭЛХИЙ

ИНДОНЕЗИЙН ШОРОНГООС 200 ХОРИГДОЛ ОРГОЖЭЭ

IV нүүрт

Дугаарын 60 мөр

## Үрээ голсон эцэг, эхчүүдэд хатуу хариуцлага тооц

Н.БАТЗАЯА

Бид дэлгүүр хэсч байх үедээ авна гэж тооцоологүй ямар нэгэн бараа таалагдвал тухайн үеийн сэтгэл хөдлөлдөө хөтлөгдөн худалдан авалт хийдэг. Гэхдээ гэртээ харьсан хойноо нөгөө бараа маань таалагдахгүй бол хэн нэгэнд өгөх аль эсвэл шууд л гаргаад хаячихдаг. Ийнхүү хэлэх болсны учир гэвэл сүүлийн үед манай улсад гологдсон бараа мэт хувь тавилантай хүүхдийн тоо нэмэгдэх боллоо. Сонин, сэтгүүл, телевиз, радиогийн мэдээгээр төрсөн хүүхдээ төөрүүлж, хаясан гэх сэрдхийлгэм мэдээлэл гарч байна. Хамгийн сүүлд гэхэд найз залуутайгаа хамт амьдрахын тулд өөрийн төрсөн хүүхдээ "Бөмбөгөр" худалдааны төвд төөрүүлсэн хэрэг олон нийтийг ихэд цочирдуулаад буй.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

# Н.ЭНХБАЯРЫГ БҮРТГЭХГҮЙ БОЛ АН-ЫГ ДЭМЖИХ НЬ ТОДОРХОЙ

Б.ТОГТОХ

Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг тодруулах сүүлийн хугацаа өчигдрөөр дуусгавар болов. Өөрөөр хэлбэл, улс төрийн намууд Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд заасны дагуу тавдугаар сарын эхний долоо хоногт нэр дэвшигчдээ тодруулж дуусах учиртай. Тэгвэл нэр дэвшигчээ хамгийн эхлээд МАН-ынхан тодруулав. Өөрөөр хэлбэл, намын Бага хурлын 310 гишүүний саналаар намын дарга М.Энхболд Ерөнхийлөгчид өрсөлдөх эрхээ энэ сарын 3-нд авсан билээ. Харин Ардчилсан нам мөн л тавдугаар сарын 3-нд нэр дэвшигчийг намынхаа 180 мянган гишүүний дунд сонгууль явуулж тодруулсан. Таван нэр дэвшигчээс хамгийн өндөр оноог Х.Баттулга авч, улмаар энэ сарын 6-нд буюу өнгөрөгч бямба гарагт намын Их хурлаас нэр дэвших эрхээ баталгаажууллаа.

Үргэлжлэл нь III нүүрт



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

# Х.БАТТУЛГА: Би ялвал Монгол ялах болно

–АН-ын наймдугаар Их хурал болж, Ерөнхийлөгчийн нэр дэвшигчээ баталгаажууллаа–



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Б.ТОГТОХ

Тавдугаар сарын 3-нд дотоод сонгууль зохион байгуулж, Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөгчөө 180 мянган гишүүний саналаар тодруулсан АН-ынхан өнгөрөгч бямба гарагт Их хурлаа хийж, нэр дэвшигчээ баталгаажууллаа. Тус намаас Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх хүсэлтэй гэдгээ таван нэр дэвшигч илэрхийлж, дотоод сонгуульд өрсөлдсөн. Ерөнхий сайд асан Н.Алтанхуяг, Хуульзүйн сайд асан Д.Дорлигжав, УИХ-ын гишүүн асан Р.Амаржаргал, Х.Баттулга, БНН-ын дарга асан Б.Жаргалсайхан нар дотоод сунгаанд өрсөлдөж, хамгийн өндөр оноог УИХ-ын гишүүн Х.Баттулга авсан юм. Тэгвэл, 180 мянган гишүүнээс санал авсан нэр дэвшигчийг батламжлах эсэхээ АН-ын 1071 гишүүн нууц санал хураалтаар өнгөрөгч бямба гарагт шийдлээ.

Үргэлжлэл нь V нүүрт

ДЭЛХИЙ

# "ДАЯАРЧЛАЛ" БА "ДАНГААРЧЛАЛ"-ЫН АЛЬ НЬ ЯЛАХ ВЭ

Б.ДАВАА

Францад "даяарчлал" эсвэл "дангаарчлал"-ынальньноёрхох нь өнөөдөр шийдэгдэнэ. Тус улсын ээлжит Ерөнхийлөгчийн сонгуулийн эхний шатны санал хураалт өнгөрсөн сарын 24-нд болж, эсрэг тэсрэг бодлого, мөрийн хөтөлбөр дэвшүүлсэн хоёр эрхэм шийдвэрлэх шатны сонгуульд тунаж үлдсэн билээ.

Улмаар өчигдөр шийдвэрлэх шатны санал хураалт болж, иргэд Елисейн ордонд Эдийн засгийн сайд асан 39 настай Эммануэль Макрон уу, эсвэл "Үндэсний фронт" намын дарга Марин Ле Пен суух уу гэдгийг шийдвэрлэлээ.

Сонгууль өчигдөр өглөө орон нутгийн цагаар 08:00 цагт орон даяар эхэлж, орой 20:00 цагт дууссан бөгөөд санал тооллогын ажиллагаа албан ёсоор эхэлжээ.

Үргэлжлэл нь IV нүүрт




| | ХААН банк Авах | Зарах | | Авах | Зарах | Худалдаа хөгжлийн банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2408.00 | 2422.00 | ФУНТ | 3077.00 | 3170.00 | АМ.ДОЛЛАР | 2408.00 | 2420.00 | ФУНТ | 3060.00 | 3179.00 |
| ЕВРО | 2610.00 | 2677.00 | РУБЛЬ | 40.40 | 42.40 | ЕВРО | 2590.00 | 2695.00 | РУБЛЬ | 39.25 | 44.35 |
| ИЕН | 21.36 | 21.67 | ЮАНЬ | 347.70 | 351.10 | ИЕН | 21.04 | 21.94 | ЮАНЬ | 348.00 | 350.90 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

УЛС ТӨР

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

# 2017 ОН ГАРСНААР 1028 ИРГЭН ИПОТЕКИЙН ЗЭЭЛД ХАМРАГДЖЭЭ

Б.ТОГТОХ

Өнгөрөгч долоо хоногийн УИХ-ын чуулганы хуралдаанаар Монгол Улсын төр тун ноцтой гэж хэлж болохуйц нэгэн шийдвэр гаргасан юм. Тодруулбал, пүрэв гарагийн чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд ороогүй байсан УИХ-ын 29 дүгээр тогтоолын 1.11 дүгээр заалтыг хүчингүй болгох асуудлыг шөнөөр хэлэлцэн баталлаа. Энэхүү зүйл заалтад хөрөнгө оруулагчид борлуулалтын орлого, төлбөр тооцоо, гүйлгээгээ Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкаар заавал дамжуулахаар заасан байсан юм. Гэсэн ч Валютын сан энэ зүйл заалтаа унагахгүй бол танай улсад зээл олгохгүй гэсэн шахалт дарамт үзүүлж, улмаар МАН-ынхан уг асуудлыг хүч түрэн батлахаас өөр аргагүйд хүрэв. Ажлын цаг дууссан хойно энэ асуудлыг оруулж ирж, улмаар 36 гишүүн дэмжиж баталлаа. Ингэснээр Монголын баялгийг зарсан мөнгө Монгол Улсад огтхон ч хамаагүй хилээр гарахаар болж байна. Дотоодын банкуудаар гүйлгээ хийгдэх эх үүсвэр хаагдах эрхзүйн орчинг тэд бүрдүүлж өгөв.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## Лу.Болд: Нэг л аймагт ялагдаж болохгүй юм уу

Чуулганы хуралдааны баасан гарагийн хуралдаанаар хоёр том хуулийн төслийг хэлэлцэж, түүнчлэн Ерөнхий сайд зам тээвэр, барилга хот байгуулалтын салбарын талаар гишүүдэд мэдээлэл хийсэн юм. Баасан гарагийн хуралдааны эхэнд уг нь хуваарь ёсоор УИХ-ын гишүүн О.Баасанхүү нараас өргөн мэдүүлсэн "Эрдэнэт үйлдвэрийн хаалт, хотын хөгжлийн сан байгуулах талаар Засгийн газарт чиглэл өгөх тухай" тогтоолын төсөл байсан ч хэлэлцсэнгүй. Мөн УИХ-ын гишүүн Лу.Болд Сүхбаатар аймагт үүсээд буй хууль бус томилгоо, хуулиар ялалт байгуулсан Засаг даргыг томилохгүй байгаа асуудлаар тавьсан асуулгын хариугаа баасан гарагийн үдээс хойшхи хуралдаанаар сонсох хүсэлтээ илэрхийлэв. Тэрбээр, “Орон нутгийн сонгуулийн үр дүнгийн асуудлаар Ерөнхий сайдад асуулга тавьсан байгаа. Улмаар УИХ-ын даргад хүсэлт тавиад эцсийн байдлаар өнөөдрийн чуулганы хуралдаанаар танилцуулахаар та шийдвэр чиглэл өгсөн. Таныг чиглэл өгсөний дагуу Сүхбаатар аймгийн иргэд 20 гаруй приус машинтай 100 гаруй иргэд ирчихсэн чуулганаар хэлэлцэх явцыг сонсоод, мэдээллийг Сүхбаатар аймгийн иргэддээ өгөхөөр ирчихсэн байгаа. Гэтэл асуудлыг дахиад долоо хоногоор хойшлуулах юм бол тэдгээр хүмүүс бүтэн долоо хоног хүлээнэ гэхээр нэлээд хүнд байдал үүсэх гээд байна. Бид уг нь Ардын намд баяр хүргэж байгаа. Та нар гайхамшигтай ялалт байгуулсан, Их хурлын танхимд 65 суудалтай үнэхээр үнэмлэхүй олонхи болсон. Дээр нь 20 аймгийн 19 аймагт нь ялалт байгуулсан. Харин гацхан Сүхбаатар аймагт ялагдсан. Тиймээс үүнийг л хүлээн зөвшөөрөх асуудал байгаа. Ганцхан аймагт Ардын нам ялагдаж болохгүй юм уу” гэлээ. Харин УИХ-ын дарга дэгийн тухай хуулийн дагуу асуулгын хариултыг одоо оруулах боломжгүй. Засгийн газар энэ талаар тун даруйхан тодорхой хариулт өгөөрэй хэмээсэн юм. Хуралдааны эхэнд Нялх балчир хүүхдийн хоол, хүнсний бүтээгдэхүүний тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох байнгын хороонд шилжүүллээ.

## 391 хогийн төвлөрсөн цэгт 2.1 сая тонн хог хаягдал цугласан гэв

Чуулганы хуралдаанаар үргэлжлүүлэн хэлэлцсэн Хог хаягдлын хуулийн төслийн талаар БОАЖ-ын сайд Д.Оюунхорол танилцуулга хийсэн юм. Уг нь энэ хуулийг 2016 оны тавдугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан ч Төрийн мэдээллийн эмхэтгэлд оруулаагүй, хуулийг ёсчлоогүй учраас буцаасан аж. Тиймээс хуулийн төслийг дахин өргөн мэдүүлж хэлэлцүүлэхээс өөр аргагүй болжээ. Монгол Улсад 2016 оны байдлаар хог хаягдлын төвлөрсөн цэг 391 байгаа бөгөөд 2.1 сая тонн хог хаягдал цугласан байна гэх тоон мэдээг салбарын сайд танилцууллаа. Мөн нийслэлд хүйтний улиралд ойролцоогоор 81 мянган тонн буюу нэг өрх ойролцоогоор 450 кг хог хаягдлыг шатааж, агаарын бохирдолд нөлөөлж байгааг онцоллоо. Хуулийн зорилго нь хог хаягдлыг баялаг гэж үзэх сэтгэхүйг олон нийтэд төлөвшүүлэх замаар хог хаягдлын зохистой менежментийг бий болгож, хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн аж. Уг хуулиар энгийн хатуу хог хаягдал болон цацраг идэвхтэйгээс бусад хий, шингэн, хатуу төлөвтэй аюултай хог хаягдалтай холбоотой харилцааг зохицуулахаас гадна төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүргийг тодорхой болгож, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаарлагыг нарийвчлан тусгажээ Мөн аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламжийг байгуулах зорилгоор 3 байршлын 37.5 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай тогтоолын төслийг боловсруулан Засгийн газраар энэ сард багтаан хэлэлцүүлэхээр төлөвлөөд байна. Хог хаягдлын тухай хуулийн төслийн талаар гишүүд асуулт асууж, хариулт авсны дараа анхны хэлэлцүүлгийг дэмжиж мөн л байнгын хороонд шилжүүлэв. Үүний дараа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр УИХ-ын гишүүн Х.Нямбаатар танилцуулга хийсэн юм. Энэ оны долдугаар сарын 1-нээс хэрэгжиж эхлэх уг хуулийн төслийг хэлэлцэх нь зөв ч эргэж харах, нягтлах учиртай хэд хэдэн зүйл заалт байгаа учраас АН-ын бүлэг дөрөв хоногийн завсарлага хүссэн юм. УИХ-ын дарга хүсэлтийг хүлээн авч, энэ хугацаанд нягталж, ирэх долоо хоногт хойшлуулахгүйгээр хэлэлцээд явах ёстой шүү хэмээлээ.

## “Дархан–Улаанбаатар”–ын замыг шинэчлэх ажил тун удахгүй эхлэнэ

УИХ-ын чуулганы үдээс хойших нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Барилга, хот байгуулалт ба зам, тээврийн салбарын бүтээн байгуулалтын ажлын явцын талаар мэдээлэл хийлээ. Өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөрөнгө оруулалтын үр дүнд 2017 оны нэг дүгээр улирлаас эхлэн цементийн үйлдвэрүүд дотоодын хэрэглээг 100 хувь хангаж, улмаар экспортлох боломжтой болжээ. Иргэдийг хямд өртөгтэй, чанартай орон сууцаар хангах төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өнгөрөгч оны арванхоёрдугаар сард Хэнтий аймгийн Хэрлэн суманд 120 айлын орон сууц ашиглалтад оруулсан бөгөөд энэ онд Орхон аймагт 315, Хөвсгөл аймагт 135, Говь-Алтай аймагт 120 айлын дуусаагүй орон сууцны барилгыг үргэлжлүүлэн барьж байгуулах аж. Мөн Улаанбаатар хотод “Буянт-Ухаа 2” орон сууцны хорооллын дуусаагүй 972 айлын 18 барилгыг энэ оны дөрөвдүгээр улиралд ашиглалтад оруулж, цаашид хэрэгжүүлэхэд бэлэн болсон “Буянт ухаа 2-2”, “Буянт-Ухаа 3”, “Эко яармаг”, “7 дугаар хороолол” зэрэг орон сууцны хороолол, хотхоны төслийг эхлүүлж, улмаар 8717 айлын орон сууц ашиглалтад орох боломжтой болно гэж Ерөнхий сайд хэллээ. Мөн энэ оны эхний гурван сарын байдлаар 1028 зээлдэгч шинээр ипотекийн зээлд хамрагдсанаар нийт зээлдэгчийн тоо 90.4 мянгад хүрсэн байна. Харин авто замын сүлжээг бий болгох зорилтын хүрээнд 2017 онд 21 чиглэлийн 1412.77 км хатуу хучилттай авто зам, 3 байршилд 639.6 у/м төмөр бетон болон хөвдөг гүүрийн барилга, их засварын ажлыг улсын төсвийн 5.29 тэрбум, Хөгжлийн банкны 23.84 тэрбум, гадаадын зээл, тусламжийн 509.93 тэрбум, нийт 539.06 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх аж. Эдгээрээс шинээр долоон чиглэлийн 506.5 км авто замын барилга болон их засварын ажлыг эхлүүлэхээр, он дамжин хийгдэж байгаа 14 чиглэлийн 973.26 км авто зам болон гурван байршилд 639.6 у/м төмөр бетон болон хөвдөг гүүрийн барилга, их засварын ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа юм байна. Авто замын хөдөлгөөний эрчим ихтэй хэсэг болох Улаанбаатар-Дархан чиглэлийн автозамыг өргөтгөн шинэчлэх ажлыг эхлүүлэхээр урьдчилсан судалгааг хийж, зураг төслийг боловсруулж дууссан бөгөөд төр, хувийн хэвшлийн түншлэлийн барих-ашиглах-шилжүүлэх нөхцөлөөр энэ хавраас хэрэгжүүлж эхлэх аж. Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан УИХ-ын гишүүн Л.Болд, Ж.Батзандан, Д.Пүрэвдорж, Д.Эрдэнэбат, Я.Санжмятав нар асуулт асууж, хариулт авлаа. Тухайлбал, УИХ-ын гишүүн Л.Болд, Хан-Уул дүүрэгт, Туул голын эрэг хавиар ажиллаад буй хайрганы карьер тойрсон олон асуудал байна. Үүнийг шийдэх ямар арга хэмжээ авах вэ хэмээн тодруулсан юм. Ерөнхий сайд, Ж.Эрдэнэбат, Засгийн газрын гишүүд өнгөрсөн долоо хоногт дүүргүүдэд ажиллсан. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Туул голын эрэг хавиар ажиллаж буй хайрганы карьеруудад газар дээр нь ажиллаад цаашид ямар арга хэмжээ авах талаар дүгнэлт гаргасан байгаа. Засгийн газраас Туул голын эрэг хариар ажиллаж буй хайрганы карьеруудыг бүгдийг нь зогсоох чиглэлийг өгсөн. Цаашид Туул голын дагуу хайрга олборлох карьер ажиллахгүй гэлээ.

ШАР МЭДЭЭ

## Элэг хөших нь дээ, эрх баригчид минь...

Ш.ДАВАА

“Эрдэнэт” үйлдвэр “Топ 100 татвар төлөгчийг тэргүүллээ” гэсэн мэдээг өглөө оройгүй сонин, телевиз, сайтуудаар нэг тараалаа. Хоёрхон сарын өмнө л “Хувийн хэвшлийнхэн орсноор үйлдвэр дампуурахад хүрсэн” гэдэг худал мэдээллээр тархи угааж байснаа ийнхүү илчлэв. Үнэхээр л “Эрдэнэт” үйлдвэр мөхлийн ирмэг дээр байсан юм бол, хувийн хэвшлийнхэн ороод хамаг техникийг нь эвдэж, баялгийг нь сороод авчихсан юм бол, төрд 100 хувь авангуутаа, Х.Бадамсүрэнг захирлаар томилонгуут Монголын аж ахуйн нэгжүүдийг тэргүүлэх боломж бий гэж үү. Жил бүр хамгийн өндөр татвар төлдөг “Оюутолгой”-г хүртэл даваад гарч иртэл шилдэг шинэ менежмент нэвтрүүлсэн бил үү. Х.Бадамсүрэн захирлын тансаглал, орлогч захирлууд, зөвлөхүүдийн нэмэгдэл, цалин хангамжийн асуудлаа л арай гэж баталж амжих хугацаа. Гэтэл хууль шүүхийн өмнүүр орж, төр 100 хувь авсан шийдвэрийн тайлбараа “Эрдэнэтийг хувийн хэвшлийнхэн аваад хамаг баялгийг нь цөлмөж байна” гэж хийсэн. Харамсалтай нь, энэ инээдмийн жүжгийн тайлал нь ийм богинохон хугацааны дараа “Топ 100-г тэргүүлсэн” мэдээллээр ил боллоо. Элэг хөших нь дээ, эрх баригчид минь...

## “Буян”-ийн Жагаа, Үүл баатар хоёрыг “эрэн сурвалжлав”

Б.ЭРХЭС

Намдаа шинэчлэлийн салхи сэвэлзүүлж, эгэл иргэдийнхээ үгийг сонсдог нам байхын төлөө зорьж буй АН-ынхан өчигдөр намынхаа наймдугаар Их хурлыг хийлээ. Хуралдаанд 300 дарга оролцсонгүй. АН-ыг дэмжиж явдаг 1071 иргэн оролцож, Ардчилсан намаас Ерөнхийлөгчид нэр дэвшигчээ сонголоо. АН-ынхан Ерөнхийлөгчид өрсөлдөгч таван хүнийг дотоод сонгуульд оролцуулж, улмаар 180 гаруй мянган гишүүнийхээ саналыг сонсч, нэгийг нь шалгаруулсан. Харин Х.Баттулга өрсөлдөөнд илүүрхсэн ч мөн л Ерөнхийлөгчийн сонгуульд намаа төлөөлөх эрхээ авахын тулд 1071 гишүүдээсээ санал авч сонгогдсон юм. Энэ удаагийн Их хуралд АН-аар овоглодог бүх л томчууд ирсэн харагдлаа. Экс гишүүд, гишүүд хүртэл ирцгээсэн байв. Тухайлбал, УИХ-ын гишүүний төлөө өрсөлдөөд ялагдсанаас хойш ажин түжин байсан УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг, Р.Бурмаа, Н.Батбаяр, А.Бакей, Б.Гарамгайбаатар нарын экс гишүүд ирсэн харагдав. Түүнчлэн, ИЗНН болон МҮАН-аас буурь сэлгэж орж ирсэн экс гишүүн М.Сономпил нар ч харагдав. Харин энэ өдөр хоёр содон зочин ирээгүй байсан нь Улсын баатар Э.Бат-Үүл, Ерөнхийлөгчийн сунгаанд өрсөлдсөн Б.Жаргалсайхан нар. АН-ын гишүүд ч тэднийг хаачсаныг намын даргаасаа асууж байсан юм. БНН-ын дарга асан Б.Жаргалсайхан АН-д элсч, улмаар Ерөнхийлөгчийн сунгаанд өрсөлдсөн. Гэтэл намынхаа Их хуралд ирээгүй нь олон хүний гайхшийг төрүүлж байв. Түүнчлэн, АН-ын нөлөө бүхий лидер Э.Бат-Үүл хуралдаа ирээгүй нь сонирхолтой байлаа. Э.Бат-Үүл Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөхийн төлөөх сунгаанд оролцоогүй шалтгаанаа “Хууль бус сонгууль болох нь нэгэнт тодорхой болсон. Тиймээс би бойкот хийхээр шийдсэн” хэмээн тайлбарласан. Тиймдээ ч намынхаа Их хуралд оролцохоос татгалзаж, бойкотоо эхлүүлсэн бололтой.

МЭДЭЭЛЭЛ

## Хоёр намын төлөөлөл Сүхбаатар аймагт ажиллана

Орон нутгийн сонгуулиар ялалт байгуулсан ч Засаг даргаа томилж чадахгүйд хүрээд буй Сүхбаатар аймгийн иргэд өнгөрсөн долоо хоногт нийслэлд ирсэн билээ. Тэгвэл өнгөрөгч баасан гарагт эдгээр иргэд төв талбайг тойрч тайван жагсаал хийсэн юм. Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Сүхбаатар аймгийн Ардчилсан намын гишүүд, дэмжигчдийн төлөөллийн тавьсан шаардлагын дагуу уулзаж ойлголцолд хүрэхээ мэдэгдсэн ч Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат тэднийг хүлээн авч уулзсан байна. Энэ талаар УИХ дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Эрдэнэбат мэдэгдэл хийлээ. Тэрбээр “Сүхбаатар аймагт үүссэн улс төрийн нөхцөл байдлын талаар хоёр нам зөвшилцөж байна. Бид тус аймгийн нөхцөл байдлыг зөв ойлгож, орон нутгийн иргэдийн амгалан тайван байдал, ажил хөдөлмөрөө хэвийн үргэлжлүүлэхэд нь онцгой анхаарах ёстой. Маргаан мэтгэлцээн нэлээд удаан үргэлжилж байна. Энэ байдал цаашид үргэлжилсээр байх юм бол мэдээж сайн үр дүнд хүрэхгүй гэдгийг хоёр тал ойлголцсон. Үүний үндсэн дээр ирэх даваа гарагт хоёр намын төлөөллийг орон нутагт илгээхээр шийдвэрлэлээ. Тэдгээр төлөөлөл орон нутгийн Иргэдийн хурлыг хуралдуулж, өөрөө удирдах байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж, цаашид хоёр нам ойлголцож ажиллахад түлхүү анхаарч ажиллах ёстой гэдэг дээр санал нэгдсэн байгаа. Аль нэг намын эрх ашиг, хүмүүсийн хоорондын харилцааны асуудал байж болохгүй, Сүхбаатар аймгийн нөхцөл байдлыг зөв гольдролд нь, ард түмний хүсэн хүлээсэн тэр хэмжүүрт нь аваачих нь зүйтэй гэж үзсэн юм. Тийм учраас ирэх долоо хоногоос Сүхбаатар аймгийн улс төрийн байдал тайван болж, хүмүүс нь хоорондоо ойлголцож, улс төрийн хүчнүүд нь харилцан хамтран ажиллах байх гэж найдаж байна. Асуудлыг нэг тийш шийдэх хэмжээнд хүрлээ” гэсэн юм.

MMINFO.
МОНГОЛЫН МЭДЭЭ
19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО
Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158
Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012
Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454
Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873
Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796
Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710
Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510
Э.САЙНЗАЯА 99197866
Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 211 тоот

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

## ҮЗЭЛ БОДОЛ

...Өмнө хэлсэнчлэн АН-тай хийсэн тохирооны дагуу тэр Өршөөлийн хуулиар суллагдсан ч өнөөдрийг хүртэл элдэв төрлийн хэрэг зөрчилтэй нэр нь холбогдсон хэвээр байгаа юм. Улс төрийн хувьд өөр өөрийн өвөрмөц замналтай, туршлагатай гурван өрсөлдөгчийг товчхон танилцуулахад иим байна...




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# Н.ЭНХБАЯРЫГ БҮРТГЭХГҮЙ БОЛ АН-ЫГ ДЭМЖИХ НЬ ТОДОРХОЙ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Харин парламентад нэг л гишүүний суудалтай МАХН-аас хэн нэр дэвших нь өнгөрөгч баасангарагийгхүртэлтодорхой бус байв. Намын дарга нь ялтай, нэр дэвших сонирхолтой хүн олон байсан учраас олон янзын таамаг өрнөсөн. Бүр тэмцэгч С.Ганбаатарыг МАХН-ынхан нэр дэвшүүлэх нь гэсэн таамаг ч гараад амжсан билээ. Гэвч баасан гарагт МАХН-ын Бага чуулган тун ажин түжин хуралдаж, намын дарга Н.Энхбаярыг нэр дэвшүүлэхээр санал нэгджээ. Үүднээсээ сэтгүүлчдийг буцааж, хэдэн хүнтэй хуралдаж хэнийг нэр дэвшүүлэх вэ гэдгээ зарлахаас татгалзсан. Тэдний энэ удаагийн улс төр их л танил сценари байх аж. Тодруулбал, 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр МАХН-ынхан мөн л намын даргаа өрсөлдүүлнэ хэмээн жагсаал цуглаан хийж, ялаас мултлах ёстой хэмээн улс төр хийж байсан удаатай. Гэсэн ч намын дарга нь өршөөлөөр мултарч, харин АН-тай хийсэн тохирооны дагуу Н.Удвалыг санал хуваах зорилгоор нэр дэвшүүлж байсан. Энэ түүхийг МАХН эргээд давтаж байна гэхэд хилсдэхгүй. Өнгөрөгч баасан гарагт тэд Эрх чөлөөний талбайд жагсаал хийж, намын даргыг Ерөнхийлөгчид өрсөлдүүлэх ёстой хэмээн эсэргүүцлээ илэрхийллээ. Н.Энхбаяр нэр дэвшигчийг бүртгэх эсэх талаар СЕХ-ноос одоогоор албан ёсоор тайлбар өгөөгүй байгаа. Харин хууль хяналтын байгууллагаас түүнийг ялтайд тооцох хугацаа дуусаагүй учраас нэр дэвших боломжгүй гэсэн хариу өгчээ. Хэрвээ СЕХ-ноос Н.Энхбаярыг бүртгэхгүй гээд татгалзсан хариу өгвөл, МАХН-ын дараагийн хийх нүүдэл юу байх нь ихээхэн сонирхол татна. Зарим эх сурвалжуудын хэлж буйгаар МАХН-ынхан АН-ын нэр дэвшигчийг дэмжих нь тодорхой. Угтаа бол МАН-ын саналыг хуваах байдлаар сонгуульд оролцох магадлалтай. АН-тай хийж буй тохироо нь намын даргаа ялаас нэг мөсөн чөлөөлөх байх уу, эсвэл мөнгө төгрөг үү гэдгийг хэлэхэд эрт байгаа юм.

### Нэр дэвшигчдийн хэн нь хэн бэ

"Х.Баттулга бөх, Н.Энхболд уяач, Н.Энхбаяр харваач. Энэ гурав эрийн гурван наадам хийх нь ээ" гэх гэмгүй маазрал цахим ертөнцөд хэдийнэ хүчээ авчээ. Нөгөө талаар нэр дэвшигчдийг хооронд нь харьцуулах, хэн нь илүүг шалгаруулах, эхнэр хүүхдийг нь шинжих, бүр монгол цустай эсэхээр нь цахим ертөнцөд хэлэлцүүлэг хийгээд эхэлчихэж. Энэ бүхнийг хуулиар хориглодог ч санал асуулга ч явуулах хүмүүс бишгүй олон бий. Өөрийн итгэл үнэмшлээ бусдад тулгах гэсэн, нөгөө талаар өрсөлдөгчөө харлуулах гэсэн захиалгат жиргээ ч олширлоо. Юутай ч, эдгээр гурван нэр дэвшигч өнгөрөгч амралтын өдрүүдээр Улсын хоёрдугаар төв эмнэлэгт нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт орсон гэх мэдээлэл байгаа юм. Ерөнхийлөгчид өрсөлдөх эрхээ намаасаа авсан эдгээр гурван улстөрч бүгд л өөр өөрийн гэсэн өвөрмөц онцлог, зан характертай. Ажил мэргэжлийн хувьд ч тэд тэс өөр. Улс төрд явж ирсэн замнал, өнөөдрийг хүртэл мөрдөж ирсэн чиг шугам нь ч адилгүй. Тиймдээ ч урьд өмнөхөөс илүү их "гал гарсан" тулаан өрнөх болов уу гэсэн таамаг байгаа юм. Тэд адилхан мөнгөтэй. Улс төрийн туршлага ч хангалттай. Тухайлбал, МАН-аас нэр дэвшигч М.Энхболдын хувьд эдийн засагч мэргэжилтэй. Монголын улс төрд 27 жил "чанагдаж" буй улстөрч. Тэрбээр, тун дардан замаар энэ өндөрлөгт хүрсэн гэхэд хэтийдэхгүй. Ганзагын наймаанд явж, бизнесийн алдаа оноог амсах гэхээс илүүтэй 1990 онд МАХН /МАН/-д элсч, улмаар дандаа даргын албан тушаалыг хашч иржээ. 1992 оноос Нийслэлийн МАН-ын 214 дүгээр үүрийн даргаар ажиллаж эхэлснээс хойш дандаа удирдах албан тушаал эрхэлж байсан туршлагатай. Хотын дарга, МАН-ын дарга, үүрийн дарга, УИХ-ын гишүүн, Ерөнхий сайд, УИХ-ын дэд дарга, дарга, Шадар сайд гэх мэтээр үргэлжилнэ. Тэр морин спортод тун ч сонирхолтой. Өнөөдрийгхүртэл морин спорт уяачдын холбоог тэргүүлдэг. Харин АН-ын нэр дэвшигчийн тухайд бизнесийн салбарт олон жил амжилттай ажилласан. 2006 оноос хойш МоАХ-г удирдаж өнөөдрийг хүртэл амжилттай чиглүүлж яваа улстөрч. Х.Баттулга нэр дэвшигчийн үндсэн мэргэжил зураач. Гэсэн ч ганзагын наймаа эрхэлж, бизнесийн салбарт алдаа оноог бишгүй үзсэн. Зах зээлд шилжсэн хүнд үед хоёр том үйлдвэрийг удирдаж, эдүгээ Монголын бизнесийн салбарт тэргүүлэгч аж ахуйн нэгж болгож чаджээ. 2006 онд АН-д элсч улс төрийн карьераа эхлүүлсэн аж. Улмаар, хонгор нутгаас УИХ-д гурван удаа сонгогдсон бол Зам тээвэр барилга хот байгуулалт, Үйлдвэр хөдөө аж ахуйн сайдаар ажиллаж байсан туршлагатай. Тэр спорт сонирхогч биш өөрөө спортын хүн. Жүдо бөхөөр олон улсад амжилттай барилдаж, улмаар Монголын жүдо бөхийн холбоог амжилттай удирдаж яваа. Харин нэр дэвшигч Н.Энхбаярын хувьд утга зохиолын ажилтан, орчуулагч мэргэжилтэй. Монголын зохиолчдын холбоонд орчуулагчаар ажиллаж, ажлын гараагаа эхэлж байсан бол улмаар 1985 онд МАХН-д элсчээ. Үүнээс хойш түүний улс төрийн карьер эхэлсэн гэхэд болно. 1992 онд анх УИХ-д сонгогдож, мөн тус ондоо Соёлын сайдаар ажиллаж эхэлсэн аж. Мөн л дардан замаар урагшилж явсан улстөрч. УИХ-д дөрвөн удаа сонгогдсон, МАХН-ын даргаар, бүлгийн ахлагчаар ажиллаж байлаа. 2000 оны сонгуулиар намаа сонгуульд удирдан орж, улмаар үнэмлэхүй суудал авч, Ерөнхий сайдаар сонгогдож байсан туршлагатай. 2005 оны Ерөнхийлөгчийн сонгуульд ялалтбайгуулж, 2009 ондцөөхөн саналаар ялагдал хүлээснээс хойш улс төрийн карьер нь уналтад орсон. Улмаар төрөөс олон арван тендер идсэн уусан хэрэгт ах дүүтэйгээ холбогдож хэцүү нэртэд хүртэл ороод амжсан. Өмнө хэлсэнчлэн АН-тай хийсэн тохирооны дагуу тэр Өршөөлийн хуулиар суллагдсан ч өнөөдрийг хүртэл элдэв төрлийн хэрэг зөрчилтэй нэр нь холбогдсон хэвээр байгаа юм. Улс төрийн хувьд өөр өөрийн өвөрмөц замналтай, туршлагатай гурван өрсөлдөгчийг товчхон танилцуулахад иим байна. Мэдээж нэр цэвэр хүн байдаггүйн адилаар тэднийг тойрсон, сайн сайхан, саар муу мэдээлэл ирэх өдрүүдэд хангалттай гарах нь тодорхой. Гэвч уншигч та өөрийнцензур, итгэлүнэмшлээр сонголтоо хийх билээ. Монгол Улсыг дараагийн дөрвөн жил толгойлж, эв нэгдлийн бэлэг тэмдэг байх Ерөнхийлөгч хэн байх вэ гэсэн том сунгаа, цаашлаад Ерөнхийлөгчийн сонгуулийн тоолуур иин өчигдрөөс албан ёсоор эхэллээ. Ирэх өдрүүдэд их л олон сонирхолтой зүйлс дэлгэгдэж, нэг нэгнийхээ булхай луйврыг уудлалцах нь дамжиггүй. Эрийн гурван наадам байх уу, эсвэл эрчүүдийн шудрага өрсөлдөөн болох уу гэдгийг хэлэхэд эрт байгаа ч монгол төрд өөр өөрийн өнгөөр танигдсан эдгээр гурван улстөрчөөс бид нэгийг нь сонгох нь тодорхой юм.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




Хууль зүй, дотоод хэргийн Дэд сайд
Б.Энхбаяр

---

Дугаарын 60 мөр

## Үрээ голсон эцэг, эхчүүдэд хатуу хариуцлага тооц

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тодруулбал, өнгөрсөн дөрөвдүгээр сард 24 настай эмэгтэй Ч, эрэгтэй С нар нэг ой долоон сартай охиныг "Бөмбөгөр" худалдааны төв дотор төөрүүлж, зугтсан аж. Одоогийн байдлаар цагдаагийн газраас тэднийг баривчлаад байгаа билээ. Энэ бол он гарснаас хойшхи ганцхан жишээ. Холбогдох байгууллагын мэдээлснээр он гарсаар хүүхдээ төөрүүлж, хаясан гэх таван удаагийн тохиолдол гарсан бөгөөд энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа гэнэ.Тэр бүү хэл хүүхдээ орцонд хаяснаас болж амиа алдсан харамсалтай тохиолдол ч бий. Хүүхдээ гологдсон бараа мэт зүгээр л гаргаад хаячихаж буй эцэг, эхчүүдээс "Яагаад хүүхдээ төөрүүлж, хаясан бэ" хэмээн асуухад тэд ихэвчлэн "Тэжээж чадахгүй байна. Сайхан амьдрахад минь садаа болж байгаа учраас" хэмээн тайлбарладаг гэх. Энэ нь яг л "Энэ бараа надад таалагдаагүй болохоор би хаячихсан" гэхтэй адилхан сонсогдоно. Гэтэл эцэг, эхчүүдийн хэев нэг энэ хэлэх хатуу үгний цаана бүхэл бүтэн хүний амь нас, улс орны ирээдүй оршин байна. Ид хийж бүтээх 20-оос дээш насны залуус ажил олдохгүй, мөнгөгүй учраас хүүхдээ тэжээж чадахгүй гэх шалтгааныг хэлээд сууна гэдэг эмгэнэл. Хэрвээ хүн өөрөө хичээл, зүтгэлтэй байж, аливаа ажлыг голохгүй хийвэл Монгол Улсад бэлээхэн ажлын байр олон бий.

Үүнийг долоо хоног бүр хэдэн мянган хувиар хэвлэгдэх "Зар мэдээ" сонин батлаад өгөх биз. Тиймээс ийм өчүүхэн шалтаг хэлж, төрсөн үр хүүхдээ төөрүүлж буй эцэг, эхчүүдэд ногдуулах хариуцлагыг чангатга. Манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн тухай хуульд энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг "Төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээ хаясан, төөрүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, 251-300 цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл 3-6 сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ" хэмээн заасан байх юм. Уг хуулиас харахад Монгол Улс эх орныхоо ирээдүй болсон хүүхэд, багачуудынхаа амийг хоёроос гурван өрөө байрны мөнгөөр үнэлж, хариуцлагагүй эцэг, эхчүүдийг 3-6-хан сар л шийтгэж байна. Гэтэл тэд улс оронд хамгийн халтай хэргийг үйлдэж буй хүмүүс шүү дээ. Нэгэнт төөрсөн хүүхэд гудамжинд гарна. Та бидний хэлж заншсанаар траншейны тэнэмэл хүүхдийн тоог нэгээр нэмнэ. Ийм иргэдийг улс орондоо бэлтгэж, өгөх хариуцлагагүй эцэг, эхчүүдийг чанга л шийтгэх хэрэгтэй. Монгол Улсын Үндсэн хуульд хүртэл үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх нь иргэн бүрийн журамт үүрэг мөн хэмээн заасан. Анхнаас нь үр хүүхдээ гологдсон бараа мэт хаях эцэг, эхчүүдийг хатуухан ял шийтгэвэл дараа дараагийн хүмүүст сургамж болох юм биш үү. Монголын залуус ажил голдог, ажилгүй, ядуу байгаа нь хариуцлагагүй эцэг, эхчүүдтэй ч холбоотой. Хариуцлагагүй эцэг, эх хариуцлагагүй хүүхдийг л өсгөж хүмүүжүүлнэ. Тиймээс бага дээр нь энэ төрлийн гэмт хэрэгтэй хатуу тэмц. Хуулийн заалт чинь арай зөөлдөөд байгаа юм биш үү, тэдэнд.

## "Боко Харам" 82 хоригдлоор олзны хүн солилцоо

Нигерийн Засгийн газраас энэ сарын 6-нд гурван жилийн өмнө лалын хэт даврагч "Боко Харам" бүлэглэлд хулгайлагдсан 200 гаруй сурагчийн 82-ыг нь хоригдлоор солилцон суллаж авснаа зарлалаа.

Тус улсын Ерөнхийлөгчийн албан ёсны твиттер хуудаст "Эрх баригчид Боко Харам бүлэглэлд олзлогдсон эмэгтэй сурагчдын зармыг нь солилцох хэлэлцээр хийснээр өнөөдөр 82 охин суллагдлаа" хэмээн бичсэн байжээ. Охидыг өчигдөр нийслэл Абужа хотод хүргэж, Ерөнхийлөгч Бухаммаду Бухаритай уулзуулсан байна.

Боко Харам, Нигерийн Засгийн газар хооронд хийгдсэн энэхүү хэлэлцээрт Швейцарийн Засгийн газар, Олон улсын улаан загалмайн нийгэмлэг зуучлах үүрэгтэй оролцжээ. Одоогоор суллагдсан охидын нэр хараахан ил болоогүй байна. Охидын биеийн байдал сайн байгаа гэнэ. Хэлэлцээр 3-4 сар орчим хугацаанд үргэлжилсэн бөгөөд эхэндээ 50 охиныг суллахаар тохирсон ч, сүүлдээ тоог нэмсэн байна. Засгийн газар цаашдаа ч хэт даврагч бүлэглэлд хулгайлагдсан охидыг суллахад анхаарч ажиллах гэнэ. Хэргийг эргэн санаулбал, 2014 оны дөрөвдүгээр сарын 14-нд хэт даврагч Боко Харам бүлэглэл Нигерийн өмнөд зүүн хойд этгээдийн Чибок тосгоны сургуулиас 276 эмэгтэй сурагчийг хулгайлсан байдаг. Үүний дараа 57 сурагч өөрсдийн хүчээр зугтаж ирсэн байдаг ч, үлдсэн 219 нь хэт даврагчдын барьцаанд байсаар байв.

Тиймээс Олон улсын улаан загалмайн нийгэмлэг, Швейцарийн Засгийн газрын зуучлалаар хэт даврагч Боко Харам бүлэглэл Нигерийн Засгийн газрын хооронд хэлэлцээр хийж, өнгөрсөн жилийн аравдугаар сард 21 охиныг сулласан. Мөн дараа нь Нигерийн арми гурван охиныг олж, аварсан гэх мэдээлэл бий. Хэт даврагч бүлэглэлийн олзонд байхдаа хүүхэд төрүүлсэн охин ч байдаг. Ерөнхийдөө 2009 оноос хойш Боко Харам бүлэглэлд хулгайлагдан, хүчирхийлүүлж амиа алдсан хүмүүсийн тоо 20 мянгыг давжээ.

# "Даяарчлал" ба "Дангаарчлал"-ын аль нь ялах вэ




**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Харин үр дүн нь өнөөдөр гэхэд бидэнд тодорхой болох билээ. Сонгуулиар нийтдээ 66546 санал авах байр ажиллажээ. Тэдний ихэнх нь оройн 19.00 цагт хаасан бол томоохон хотуудад нэг цагаар сунаж буюу 20.00 цаг хүртэл саналаа өгөх боломжтой байхаар зохицуулалт хийжээ.

"Үндэсний фронт" намын нэр дэвшигч Марин Ле Пений хувьд энэ удаагийн сонгуульд эцгийнхээ дутууг гүйцээхээр өрсөлдөж буй. Тодруулбал, түүний эцэг Жан Мари Ле Пен 2002 оны Францын Ерөнхийлөгчийн сонгуульд "Үндэсний фронт" намаас нэр дэвшиж байжээ. Тэрбээр Марин Ле Пентэй төстэй буюу мөн л цагаачлалын хатуу бодлогыг санал болгож байсан байна. Тухайн үедээ хэдийгээр шийдвэрлэх шатанд тунаж үлдсэн ч, Ерөнхийлөгч болж чадаагүй гэдэг.

Харин түүний охин өнөөдөр эцгийнхээ дутууг гүйцээж, Францын Ерөнхийлөгч болох эсэх нь тодорхой болох юм. Марин Ле Пен энэ удаагийн сонгуулийг Э.Макроны дэвшүүлж буй гадаад худалдааны бодлого, цагаачлал, "даяарчлал" болон Франц улсын хил хязгаар, үндэсний онцлогийг хамгаалах "дангааршил" хоорондын тулаан гэж тодорхойлсон юм.

Тэрбээр шийдвэрлэх шатны сонгуульд Эммануэль Макроныг ялсан тохиолдолд Францын гишүүнчлэлийг өөрчлөх талаар ЕХ-ны гишүүн орнуудтай нэн даруй хэлэлцэнэ гэдгээ илэрхийлсэн бол түүний өрсөлдөгч Франц улс Европын амин сүнс байж, хөрш зэргэлдээ орнуудтайгаа нягт харилцаатай байх ёстой гэх зарчмыг баримталдаг. Түүнчлэн, "Үндэсний фронт" намын даргын дэвшүүлсэн цагаачлалын бодлого АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трампынхтай төстэй бөгөөд цагаачдын урсгалыг хязгаарлах, албадан гаргах зэрэг заалтууд багтсан. Гэтэл Эммануэль Макроны цагаачлалын асуудалд баримтлах бодлого нь тэс ондоо. Учир нь тэрбээр хэрэв Ерөнхийлөгчөөр сонгогдвол ажлаа авсан эхний зургаан сардаа багтааж, орогнол хүссэн цагаачдыг хүлээн авахаа амласан юм. Үүний зэрэгцээ Францыг цагаач, дүрвэгсдийг халуун дотноор хүлээн авдаг улс болгохоо илэрхийлжээ. Энэ мэтээр тэдний дэвшүүлсэн "даяарчлал" ба "дангаарчлал"-ын бодлогын алийг нь сонгохоо францчууд өчигдөр шийдлээ. Харин өнөөдөр гэхэд үр дүн нь албан ёсоор тодорхой болох юм.

Э.Макрон, Ле Пен нар эхний шатны санал хураалтад тийм ч их саналын зөрүүгүй тэргүүлсэн байдаг. Гэвч, шийдвэрлэх шатны сонгуулийн өмнө явуулсан хамгийн сүүлийн олон нийтийн санал асуулгад Макрон 62 хувь, Марин Ле Пен 38 хувийн саналыг тус тус авчээ. Энэ байдлаар францчууд "даяарчлал"-ыг сонгох магадлал өндөр байна. Хэрэв Э.Макрон сонгуульд ялалт байгуулбал, Франц түүхэндээ анх удаагаа тус улсын Ерөнхийлөгчийн бодлогод нөлөөлөхүйц нөхрөөсөө 24 насаар эгчмэд тэргүүн хатагтайтай болох юм.

## Индонезийн шоронгоос 200 хоригдол оргожээ

Индонезийн Суматра арлын шоронгоос 200 орчим хоригдол оргожээ. Улмаар цагдаа нар шуурхай ажилласны дүнд оргосон хоригдлын 80 орчим хувийг нь дахин баривчилсан талаар эх сурвалж мэдээллээ. Харин баригдаагүй хоригдлыг эрэн сурвалжилж байгаа гэнэ.

Суматра арлын Риау мужийн Пеканбар хотын нэгэн шоронгоос дээрх тооны хоригдлууд оргожээ. Тэд шоронгийн сүмийн мөргөлд оролцсоныхоо дараа "нэг камерт хэтэрхий олон хүн байна. Энд бөгс эргэх зай алга" гэж гомдол мэдүүлж байжээ. Гэвч үүнийхээ дараахан нь шоронгийн хаалгыг эвдэж, оргон зугтжээ.

Оргосон 200 хоригдлын 140-ийг нь цагдаа нар барьжээ. Оргох үед хоригдлууд шоронгийн хувцас өмсөөгүй байсан учир сул чөлөөтэй яваа 60 хоригдол энгийн иргэн мэт "жужиглэн" олны дунд орсон байж магадгүй гэдгийг цагдаа нар онцолсон байна. . Индонезийн шоронгуудын даац хэтэрч, хэт олон хоригдол нэг өрөөнд байгаа нь тулгамдсан асуудал болоод байна. Пеканбар хотын энэ шоронд 360 хүртэлх тооны хоригдол байх ёстой атал даац хэтрүүлэн 1800 орчим хоригдол байдаг бөгөөд тэдэнд ердөө зургаан харгалзагч л хяналт тавьдаг гэнэ.

## Филиппинд хоёр удаагийн хүчтэй дэлбэрэлт боллоо

Филиппиний нийслэл Манила хотын хуучны гудамжинд хоёр удаагийн хүчтэй дэлбэрэлт болсны улмаас хоёр хүн нас барж, зургаан хүн шархаджээ.

Цагдаагийн алба хаагчид эхэндээ дэлбэрэлтийг террорист халдлага биш гэж үзэж байсан юм. Гэвч, түүний дараа хэт даврагч "Лалын улс" бүлэглэлийн салбар Амак гэх байгууллага уг халдлагыг үйлдсэн гэдгээ өөрсдөө хүлээжээ. Манила хотын цагдаагийн газрын дарга Оскар Албаялдегийн хэлснээр эхний дэлбэрэлт бямба гарагийн 18:00 цагийн үед Кьюапо гэх дүүргийн лалын шашны сүмийн ойролцоо болж, хоёр хүн нас барж, дөрвөн хүн шархаджээ. Тэсрэх бөмбөгийг мотоциклтой хоёр амиа золиослогч этгээд дэлбэлсэн байна. Тэдний нэг нь мотоциклоо унаж, нөгөө нь гялгар уутанд тэсрэх бөмбгөө хийн барьсан байжээ.

Харин удаах дэлбэрэлт нь 20:30 цагийн үед мөн сүмийн ойролцоо болжээ. Тухайн үед эхний удаагийн дэлбэрэлт болсон газарт үзлэг хийж явсан хоёр цагдаагийн ажилтан өртөж гэмтсэн байна. Дэлбэрэлт хувцас, гоо сайхан зэрэг төрөл бүрийн бараа зардаг дэлгүүрийн ойролцоох зам дээр болжээ. Филиппиний иргэдийн дийлэнх нь католик шашинтай ч, тодорхой тооны лалын шашинтнууд байдаг гэнэ. Улмаар тэдний зарим хэсэг нь Кьюапо дүүрэгт амьдардаг аж.

## Хорт хий цацагдсаны улмаас 200 хүүхэд хорджээ

Энэтхэгийн нийслэл Нью Дэли хотод энэ сарын 6-нд контейнер бүхий талбайд хорт хий цацагдсаны улмаас ойролцоох сургуулийн 200 орчим сурагчийн нүд болон хоолойд хэвийн бус шинж тэмдэг илэрч, эмнэлэгт хүргэгджээ.

Энэ талаар орон нутгийн цагдаагийн газраас мэдээлсэн байна. Албаны эх сурвалжийн мэдээлснээр хорт хий цацагдах үед сургууль хичээллэж байжээ. Гэтэл гэнэт анги танхимд үйлдвэрлэлийн зориулалттай химийн хорт бодис үнэртэж эхэлсэн байна. Үүний улмаас 200 орчим сурагчдад нүд болон хоолой нь хорсох шинж тэмдэг илэрч ойролцоох дөрвөн эмнэлэгт хуваагдан хүргэгджээ. Гэхдээ ноцтой хохирсон сурагч одоогоор байхгүй. Өвчтнүүдийн биеийн байдал тогтворжсон байна. Харин холбогдох албаныхан ямар төрлийн бодис агаарт цацагдсаныг тодруулахаар ажиллаж эхэлжээ.

## Дэлхийн зүүн төвийн үзэл баримтлалтай намууд Улаанбаатарт чуулна

Энхтайван, шударга ёс, эв нэгдлийн төлөөх "Прогрессив Алиансе" нэгдлийн Бага хурал энэ сарын 25, 26-нд Улаанбаатар хотноо болно. Дэлхийн зүүн төвийн үзэл баримтлалтай 140 улс төрийн намыг эгнээндээ нэгтгэсэн энэхүү нэгдэл нь социал демократ буюу нийгмийн ардчилсан үзлийг түгээн дэлгэрүүлэх зорилготой юм. Тус нэгдлийн анхдугаар уулзалт Бүгд Найрамдах Итали Улсын нийслэл Ром хотноо 2012 оны арванхоёрдугаар сард дэлхийн 42 орны улс төрийн намын оролцоотойгоор зохион байгуулагдсан юм. Энэ цаг үеэс л "Прогрессив Алиансе" нэгдлийг албан ёсоор байгуулах санаачлага гарч, 2013 оны тавдугаар сарын 22-нд ХБНГУ-ын Лейпциг хотод дэлхийн дэвшилтэт социал демократ намууд болон байгууллагуудын сүлжээнд суурилан байгуулсан. Эдүгээ дэлхий хэмжээнд энх тайван, ардчилал, хүний эрх, нийгмийн шударга ёс, нийцтэй ажиллагааны хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. "Прогрессив Алиансе" нэгдлийг үүсгэн байгуулснаар олон






улсын орчин үеийн улс төрийн намуудын хамтын ажиллагааны талаар олон жилийн туршид өрнөсөн маргаанд цэг тавьсан, нөгөө талаар хамтын ажиллагааны шинэ эхлэл болсон гэж үздэг. "Прогрессив Алиансе" нь удирдах хороо, зохицуулагч, удирдах зөвлөлөөс бүрддэг цомхон бүтэцтэй нэгдэл юм. Европын Социалистуудын нам, Европын парламент дахь социалистууд ба ардчилагчдын бүлэг, Азийн Ардчилсан Социалиастуудын Сүлжээ, Африкийн Дэвшилтэт Алиансуудын төв, Арабын социал демократ форум зэрэг бүс нутгийн улс төрийн намуудын сүлжээний 140 гаруй нам, байгууллагууд "Прогрессив Алиансе"-ын гишүүн юм.

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

# Х.Баттулга: Би ялвал МОНГОЛ ялах болно



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

–АН–ын наймдугаар Их хурал болж, Ерөнхийлөгчид нэр дэвшигчээ баталгаажууллаа–

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

АН-ынхан шат шатны сонгуулийн ялагдлын дараа намаа шинэчлэх ажлыг шат дараатай эхлүүлсэн билээ. Улмаар гишүүдээ сонсдог, нээлттэй, дотоод ардчилалтай нам байх зорилго дэвшүүлж, сонгуульт албан тушаал болгоныг гишүүдээрээ шийдүүлж байхаар Үндсэн дүрэмдээ тусгасан. Тиймдээ ч Их хурлаараа дан ганц Ерөнхийлөгчид нэр дэвшигчээ баталгаажуулах бус Үндэсний бодлогын хорооны 389 суудлын төлөө өрсөлдөж, ялалт авсан гишүүдээ ч нууц санал хураалтаар баталгаажуулах эсэхээ шийдлээ. Их хурлыг АН-ын дарга С.Эрдэнэ нээж үг хэлэв. Тэрбээр, “Ардчилсан шинэчлэлийн үйл хэргээсээ алхам ч ухрахгүй шаардлагабидниймөнөтулгамдаж байгаа. Намын шинэчлэлийн амин сүнс болсон бүх гишүүдийнхээ саналаар намын бүр шатны удирдах албан тушаалтнуудыг сонгосон. Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийг анх удаа намын бүх гишүүдийн санал асуулгаар тодрууллаа. Энэ улс төрийн намын шинэ туршлага байлаа” хэмээсэн юм. Намын даргыг үг хэлсний дараа АН-ын Үндэсний бодлогын хороонд нэр дэвшиж ялалт байгуулсан 389 төлөөлөгчийг АН-ын нарийн бичгийн дарга С.Эрдэнэболд нэг бүрчлэн танилцууллаа. Үндэсний бодлогын хорооны гишүүнд Үндсэн дүрэмдээ заасанчлан эмэгтэйчүүдийн квотыг тусгаж өгчээ. Мөн залуустаа боломж олгох үүднээс нэг суудлыг зөвхөн залуучуудад зориулсан байна. Гишүүдээ танилцуулсны дараа намын дарга С.Эрдэнэ дотоод сонгуульд ялалт байгуулсан Х.Баттулгыг Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлсэн намын тогтоолыг уншиж танилцуулсан юм. Ингэснээр бодлогын хорооны гишүүдийг жинхлэх, Х.Баттулга нэр дэвшигчийг батламжлах гэсэн хоёр асуудлаар нууц санал хураалт явж, үдээс өмнөх хурал өндөрлөлөө.

## Х.Баттулга 96.3 хувийн санал авч, нэр дэвших эрхээ баталгаажууллаа

Үдээс өмнөх хуралдаан нууц санал хураалтаар өндөрлөж, хоёр цаг орчим хугацаанд завсарласан юм. АН-ын наймдугаар Их хуралд 21 аймаг, 360 гаруй сум, нийслэлийн есөн дүүргээс 1071 жирийн гишүүд оролцохоор иржээ. Үүнээс гадна УИХ-ын гишүүн болон экс гишүүд ч хуралдаа ирцгээсэн харагдлаа. Түүнчлэн, УИХ-ын гишүүн асан Х.Баттулгатай хамт дотоод сонгуульд өрсөлдсөн Р.Амаржаргал, Н.Алтанхуяг, Д.Дорлигжав нар ч ирсэн байсан юм. Энэ удаагийн хуралдаан өмнөхөөс тун өөр байгаа нь ажиглагдаж байв. Танхимын уур амьсгал ч эерэг, нэр дэвшигчдээ сэтгэл хангалуун байгаа нь илт байлаа. Завсарлага дуусч, нууц санал хураалтын дүн гарахад Х.Баттулга нэр дэвшигчийг 96.3 хувийн саналаар батламжилснаас харагдаж байлаа. Хуралдаанд оролцсон 1071 төлөөлөгчөөс 925 төлөөлөгч Үндэсний бодлогын хорооны 389 гишүүнийг батламжлах нууц санал хураалт өгч, 919 гишүүний саналыг хүчинтэйд тооцжээ. Ингэснээр 98.5 хувийн саналаар ҮБХ-ны гишүүдийг батламжилсан юм. Харин Х.Баттулга нэр дэвшигчийг баталгаажуулах санал хураалтад 938 гишүүн санал өгч, дөрвөн санал хүчингүй болсноор 934 санал хүчинтэйд тооцогджээ. Үүнээс 903 гишүүн дэмжиж санал өгч, 96.3 хувийн саналаар нэр дэвшихийг нь баталгаажуулсан юм. Үүний дараа намын дарга С.Эрдэнэ санал хураалтыг баталгаажуулсан намын тогтоолыг уншиж танилцуулаад Ерөнхийлөгчид нэр дэвшихийг нь баталгаажуулсан намын батламжийгХ.Баттулгадгардуулан өгөв. Шат шатны гишүүдээсээ дэмжлэг авч, нэр дэвших эрхээ баталгаажуулсан Х.Баттулга нэр дэвшигч наймдугаар хуралдаанд оролцож буй журмын нөхөддөө хандаж үг хэллээ.

## Х.Баттулга: Би бие сэтгэлээрээ бэлэн байна

Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх эрхээ баталгаажуулсан нэр дэвшигч Х.Баттулгын хэлсэн үгийг бүрэн эхээр нь хүргэе. Тэрбээр, “Журмын нөхөд өө, эрхэм төлөөлөгчид өө. Юуны өмнө Монгол Улсын Ерөнхийлөгчид Ардчилсан намаас нэр дэвшигчийг тодруулах бүх гишүүдийн санал асуулгад оролцож, надад итгэл үзүүлсэн журмын нөхөддөө талархлаа илэрхийлье. Ардчилсан намын шинэчлэлийг амьдралд хэрэгжүүлж, гишүүдийн оролцоотой нам болон хувирах бүтээлч үйл явцыг эхлүүлж, удирдаж буй намын дарга С.Эрдэнэ болон намын удирдлагын багийн гишүүдэд мөн баярласан талархсанаа хэлье. Ардчилсан нам өөрчлөгдөх, шинэчлэгдэх явц эргэлт буцалтгүй эрчээ авч өдрөөс өдөрт бодлогын нам, гишүүдээ сонсдог, гишүүдээ оролцуулдаг, олонхийн шийдэлтэй нам болж байгаа нь Монголын улс төрийн тавцанд Ардчилсан намын торойн ялгарч буй гол ялгаа, давуу тал гэдэгт би огтхон ч эргэлзэхгүй байна. Цаашид ч шинэчлэл улам бүр эрчимжиж Ардчилсан нам хүчирхэгжих болно. Монголчууд, Монгол Улс түүхэн эргэлтийн цаг үе дээр ирээд байгаа хариуцлагатай мөчид Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгчийг сонгох сонгууль болох гэж байна. Эргэлтийн цаг үе гэдэгт би юуг хэлэх гэж байна гэхээр төрийн бүх шатны удирдлага, засаглал, нэг намын хараа хяналтад бүхлээрээ орж, ард түмний эрх ашиг хөсөрдөж, эрх баригчид сонгуулиар санал авсан сайхан сайхан амлалтуудаасаа бөөн бөөнөөр буцаж эхэллээ. УИХ дахь хэт олон суудалдаа эрдсэн МАН сонгогчдын санаа бодол, дуу хоолойг үл тоон хүч түрэх, дарангуйлах, тулгах замаар бодлогоо тулган шийдвэрээ гаргаж байна. Тэд хэдий олонхи ч гэлээ эв нэгдэлгүй, гаргасан шийдвэртээ туйлбаргүй цаг үргэлж эргэж буцаж байгаа нь эдийн засгийг туйлдуулж, царцанги байдалд оруулж байна. Үүнийг дагаад иргэдийн амьжиргаа ч царцаж, хөшиж байна. Сонгуульд ялж, Засгийн эрх авсан цагаасаа хойш МАН-аас тууштайгаар нэг мөр шийдсэн нэг ч асуудал одоогоор алга. Хамгийн сүүлд ОУВС-ийн хөтөлбөрт хамрагдах эсэхээ хүртэл гурвантаа ухарч, няцаж байж эцэст нь Үндэстэн дамнасан корпорацийн ашиг сонирхолд бүрэн бууж өгсөн байдлаар шийдэхийг та бид харлаа, үзлээ, сонслоо. /Рио Тинто компанийг дансаа Монголд байршуулахыг шахсанаас шалтгаалж ийм шийдвэр гаргасан./ МАН бол цөөнхийн эрх ашгийг эрхэмлэгч, олигархиудыг тэжээн тэтгэгч нам гэдгээ өнгөрсөн хугацаанд бүрэн харууллаа. Тэд ядарсан иргэддээ ачааны хүндийг үүрүүлж, долоон төрлийн татвар нэмж дарамтлах хэрнээ Чингис бондоос асар их хэмжээгээр нь зээл авчихаад эргэж төлөх талаар бодох ч үгүй суугаа гишүүддээ юу ч хэлж чадахгүй байна. Уг нь тэднээс эргэн төлөлтийн мөнгийг нь авчихад л татвар нэмснээс гурав дахин их орлого олох байлаа. Энэ мэтчилэн сонгуулийн амлалтаа мартаж, сонгогчдоо дарамтлах нь цаашид улам бүр хараа хяналтгүй даамжирч, засч залруулж болшгүй хэмжээнд хүрэх, дарангуйлал руу гулсан орох урьдач нөхцлүүд хэдийнэ бүрджээ. МАН-ын бодлого шийдвэр жирийн гишүүддээ хүртээлгүй байна.

Тэд хэдхэн хүний хүрээнд асуудлыг ярьж, тэдний шийдвэрийг гишүүддээ, хамтын удирдлагын байгууллагадаа тулган хүлээлгэх замаар шийдвэрээ гаргаж байгаа нь улам бүр тодорхой болсоор байна. Хамгийн гол аюул нь эдийн засаг нэг улсаас хараат болох нөхцлийг эрх баригчид сэм сэмээр хэрэгжүүлж, Монголын эдийн засгийг олон улсаас бүрэн таслаж дөнгөлөө. Та бид өдөр бүхэн өмнөд хөршийн эдийн засаг, худалдаа бизнесийн давамгайлал, түрэлтийн мэдээг уншиж байна. Хятадуудыг визгүй нэвтрүүлдэг болгоё, давхар иргэншил олгоё, сая саяар нь авчиръя гэх уриалгууд төрийн дээд төвшнөөс ил тод сонсогдох болжээ. 1990 онд Монголын ардчилагчдын амь бие үл хайрлан тэмцэж, сэргээсэн тусгаар тогтнол бүдэгрэх, алдагдаж болзошгүй нөхцөл байдал руу эрх баригчид өдрөөс өдөрт түлхэж байна. Саяхан Монгол Улсын Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж УИХ-ын чуулганы индэр дээрээс нэгэн ноцтой, монгол хүн бүр тунгаан бодох ёстой үгийг хэллээ. УИХ дахь МАН-ын бүлгээс санаачлан хэлэлцэгдэж байгаа Хөрөнгө оруулалтын банкны тухай хуульд гадаадын банк Монголд орж ирэн энэ хуулиар дамжуулан Монгол Улсыг орд газар, баялагтай нь “Барьцаалах” эрхийг олж авах нөхцлийг хангах гэж байгаа юм. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хуулийн энэ заалт нь томоохон хэмжээний зээл авсан иргэд, аж ахуйн нэгж авсан зээлээ төлж чадахгүй тохиолдолд барьцаалсан лицензүүд нь хураагдаж, улмаар цааш дамжин зарагдаж, Монгол Улсын газар нутгийн бүрэн бүтэн байдал алдагдах аюул тулгараад байгааг УИХ-ын гишүүдэд сануулаад “Монголын талаар гадныхан эртнээс хүн нь чухал биш, газар нь чухал” гэсэн бодлого баримталж ирсэн гэдгийг анхааруулсан билээ. Би энэ асуудал дээр Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржтой санал нэг байна. Ардын намын санаачилсан хуулиас гадны банк Монголын газар нутгийг барьцаалахтай холбоотой зүйл заалтыг хасах ёстой. Энэ бол монгол хүний ухаан санаанд буухгүй зүйл. Монгол хүнээс гармааргүй энэ мэт зүй бус санаачилга ахин хэд ч гарахыг бид хэлж мэдэхгүй. Тийм учраас сонор сэрэмжтэй байх нь юунаас ч чухал болоод байна. Ардчилсан хувьсгалын нэгэн том ололт нь Монгол Улс хойд хөршийнхөө дагуул улс байхаа больж, Тусгаар тогтносон, бүрэн эрхт улс гэдгээ жинхэнэ утгаар нь тунхагласан явдал байсан. Тэгвэл өнөөдөр олон улсын шинжээчид, судлаачид нэгэн дуугаар Монголыг өмнөд хөршийн эдийн засгийн хяналтад бүрэн орсон хэмээн дүгнэх боллоо. Бид Тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа хадгалах уу, алдах уу гэдэг зарчмын сонголтын өмнө тулж иржээ. Би коммунистуудын харлуулан харуулах гэж хичээдэг шиг хятадыг үзэн ядагч биш ээ. Би хятадын урт түүх, баялаг соёл, уламжлалыг хүндэтгэдэг, Хятадын ард түмний ажилч хичээнгүй, хөдөлмөрч чанарыг хүндэлдэг. Гэхдээ бизнес эрхэлж байсан хүний хувьд аливаа худалдаа, эдийн засгийн харилцаа хоёр талдаа хоёуланд нь ашигтай тусч байж, урт удаан тогтвортой хамтын ажиллагаа, итгэлцэл бий болдгийг хатуу ойлгосон. Би Монгол Улсад гаднаас ямар нэг ачлал үзүүлэх, тусламжийн гар сунгах, халамжлахыг хүсэх, шаардахын эсрэг байдаг. Харилцан ашигтай худалдаа, хамтын ажиллагааны төлөө бат зогсдог. Монголтой урт хугацааны, итгэлцэл төгс хамтын ажиллагаа явуулах нь тун энгийн, маш амархан. Монголоос дан ганц түүхий эд бус бэлэн бүтээгдэхүүн худалдаж ав, монгол хүнийг ажилтай байлгахад тусла. Ердөө л энэ. Хамаг дэлхийн шударга улстай хамтран нэгдсэн эгнээг бэхжүүлж гэх төрийн дууллын үг бол бидний зарчим. Бид эрх тэгш, шударга харилцааг л эрхэмлэнэ. Үүнийг ойлгож, энэ нөхцлийг хангах хэнтэй ч болов монголчууд хамтран ажиллах, хөрөнгө оруулалтыг нь дэмжих, ажиллах нөхцлийг бүх талаар хангахад бэлэн байдаг. Би үүнийг бодит хэрэг болгох, энэ зарчмыг Төрийн үйл хэрэгт хэм хэмжээ болгохын төлөө Ерөнхийлөгчид нэр дэвшин өрсөлдөх гэж байна. Монголын эрх ашиг, монголчуудын сайн сайхан амьдрах хүсэл эрмэлзэл бол миний чигийг заагч, замыг гэрэлтүүлэгч эрхэм дээд хүч юм.

Монгол газар шороон дээр монгол хүн цээж дүүрэн амьсгалж, толгой өндөр, нүүр баатар, элбэг хангалуун амьдарч, ажиллах тэр цагийг наашлуулахын төлөө би чадах бүхнээ хийх гэж улс төрд орсон. Шийдвэрлэх цаг мөч тулж ирлээ. Би бие сэтгэлээрээ бэлэн байна. Хүч тэнцвэргүй тулаан биднийг хүлээж байгаа. Эрх баригчид төрийн санхүү, хүн хүчний нөөц, давуу талаар түрээ барин, цахим луйвар, олигархиудын мөнгөн дэмжлэгт дулдуйдсан байдлаар сонгуульд оролцох гэж байгаагаа бодитоор үзүүлэн бардамнахыг саяхан хийсэн ТВ шоунаас нь олон бүгдээр харлаа, ойлгож мэдэрлээ. Ардын нам олигархи бүлэглэл, гаднаас хамааралтай бизнесийнхэнд найдаж байгаа бол би монголчууддаа, эгэл жирийн ард түмэн, сонгогчиддоо найдаж байна. Мөнгө дийлэх үү, монголчууд дийлэх үү гэдгийг одоо цөмөөрөө үзэцгээе. Би “шийдвэрлэх тулаанд” та бүхэнтэйгээ ороход бэлэн. Бид хамтдаа ялна аа. Хамтын хүч ямагт амжилтад хүргэдгийг миний туршлага нотлоно. Мөнгө бүх зүйлийг шийддэггүйг миний сэтгэл мэднэ. Хариуцлага, сахилга бат бол ялалтын зам мөр мөн. Би журмын нөхөдтэйгээ хамтран боловсруулсан мөрийн хөтөлбөр - Тав дахь Ерөнхийлөгчийн эрмэлзэх таван зүйлийг бүрэн хэрэгжүүлсэн дүнтэйгээр сонгуульт хугацаагаа дуусгахыг хичээн эрмэлзэх болно. Миний эрмэлзэж буй зүйлс бол монголчуудын чин эрмэлзлэл. Монголын эх орончдын эртнээс нааш эрмэлзэж ирсэн тэр зүйлсийг би удирдлагаа болгон ажиллах болно. Үе үеийн эх орончид “...төр юугаан дахин шинэчлэн босгож, тасарсныг залгаж, хэмхэрснийг эвлэрүүлэн нийлүүлэхийг эрмэлзэн” “ард олны эрхийг мандуулж, эрдэм боловсролыг хөгжүүлэн, нийтээр тэгш жаргах, улс үндсээрээ дэвшин хөгжих төрийг босгох”-ыг чармайн зүтгэж ирснийг би үргэлжлүүлэхээ, хэрэгжүүлэхээ амлая. Би буруud хатуу, зөвд зөөлөн байж, эх орон ард түмнийхээ төлөө хариуцлагыг тооцсон шиг тооцдог, гавьяаг шагнасан шиг шагнадаг, сахилга батыг чанд сахиж, хуулийг мөрдлөг болгодог Ерөнхийлөгч байхыг хичээн эрмэлзэх болно. Би монгол хүний сайн сайхны төлөө, Монгол Улс мандан бадрахын төлөө бүхнээ зориулахаа андгайлъя. Би ялвал Монгол ялна. Бие бөх бол сэтгэл бөх. Бид хамтдаа чадна аа. Дээдсийн хийморь, сүлд биднийг ивээнэ. Гадны гар хөл биш, цөөн тооны олигархиудын найдлага биш ард түмэн, монголчууд ялсан сонголт байгаасай. Монголчууд нийтээр тэгш жаргах цаг ирнэ ээ. Монголчууд ялна аа! Бидний Монголчуудсэрэнмандахболтугай! Сайн үйлс дэгжин дэлгэрэх болтугай! Эрх чөлөө, тусгаар тогтнолоо бататгах шийдвэрлэх чухал сорилтод хамтдаа ялъя” хэмээсэн юм. Мөн Их хурлынхаа индрээс дотоод сонгуульд өрсөлдсөн Р.Амаржаргал, Д.Дорлигжав, Н.Алтанхуяг нар Х.Баттулгыг дэмжиж, эв нэгдэлтэйгээр Ерөнхийлөгчийн сонгуульд оролцохоо илэрхийлсэн бол АН-ын дарга С.Эрдэнэ, АН-ын бүлгийн дарга Д.Эрдэнэбат нар АН энэ удаад юу юунаас илүү эв нэгдэлтэй байж, Ардчилсан Ерөнхийлөгчтэй болохын төлөө жирийн гишүүдтэйгээ хамтдаа тууштай зүтгэнэ хэмээв. Хуралдааны төгсгөлд АН-ынхан нэр дэвшигчийнхээ мөрийн хөтөлбөрийг хаалттай журмаар хэлэлцэв. Мөрийн хөтөлбөрийг Үндэсний аудитын газарт шалгуулж, улмаар шаардлагатай гэж үзвэл ҮБХ-оор хэлэлцэнэ гэдгийг намын дарга С.Эрдэнэ хэлж байлаа.

# ЦАГ ҮЕ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ



# Ц.Бямбасүрэн: “МОД ТАРИХ ӨДӨР”-ИЙГ ЭНЭ САРЫН 13, 14-НД ЗОХИОН БАЙГУУЛНА

Б.САРУУЛ

*Энэ сарын 13, 14-нд бүх нийтээрээ мод тарих өдөр тохиож байгаатай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ойн бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн Ц.Бямбасүрэнтэй ярилцлаа.*

**-“Мод тарих үндэсний өдөр” сарын аян өрнөж байна. Энэ хүрээнд салбар яамны зүгээс ямар ажлуудыг хийж хэрэгжүүлж байна вэ?**

-Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйл, Ерөнхийлөгчийн 2010 онд гаргасан 63 дугаар зарлигийн дагуу жил бүрийн хавар, намрын улиралд бүх нийтээр мод тарих сарын аяныг зохион байгуулдаг уламжлал тогтоод байна. Ерөнхийлөгчийн зарлигт “Бүх нийтээр мод тарих өдөртэй байна” гэж зарласан. Энэ ч утгаараа манай яамны зүгээс жил бүрийн V, X сарын хоёр дахь долоо хоногийн амралтын өдрүүдийг бүх нийтээр мод тарих өдөр болгон хэвшүүлж чадсан. Энэ жил тавдугаар сарын 13, 14-нд “Мод тарих өдөр”-ийг зохион байгуулахаар тов гарсан. Энэ өдрийг угтаж сарын турш хэд хэдэн чухал арга хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас санаачлан зохион байгуулж байгаа. Тухайлбал “Тарьц суулгацын үзэсгэлэн худалдаа 2017” арга хэмжээ энэ амралтын өдрүүдэд МҮЭСТО-нд боллоо. Бид тодорхой хугацаанд мод тарьж байгаа ч ургуулах, арчлах тал дээр хангалтгүй байгаа нь иргэдийн мод тарих мэдлэг, туршлага хомс байгаатай холбоотой гэдэг дүгнэлтэд хүрсэн. Тиймээс бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулдаг аймаг нийслэл, сум дүүргийн Засаг даргын Тамгын газар, бусад мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулж байна. Бүх нийтээр мод тарих өдрүүдэд хэн хаана ямар мод тарьж болох вэ гэсэн чиглэлүүдэд ажил зохион байгуулна.

**-Тарьц суулгацын үзэсгэлэн худалдаанд яамны зүгээс ямар шалгуур тавьж байгаа вэ. Чанаргүй бүтээгдэхүүн нийлүүлснээс болж тарьсан мод ургахгүй байх тохиолдол байдаг шүү дээ?**

-Тарьц суулгацын үзэсгэлэн худалдаанд мэргэжлийн байгууллагын өндөр хяналт тавина. Сайн дураараа мод тарих сонирхолтой иргэдийг стандартын тарьц суулгацаар хангах нь чухал. Стандартын шаардлага хангасан гэдэгт үндэсний систем нь хэрхэгжилтэй байна вэ, гарал үүслийн хувьд мод үржүүлгийнх байна уу гэх зэрэг нарийн зүйлс хамаардаг. Өмнө нь уулнаас мод ухаад ч юм уу, их хэмжээгээр хууль бусаар импортын тарьц суулгац оруулж ирэх тохиолдол гардаг байсан юм билээ. Энэ нь эргээд тарьсан мод нь амьдрах чадваргүй, тухайн орчиндоо зохицохгүй байх хүндрэл дагуулдаг. Иргэд маань ногоон л байвал тарьц сайн ургана гэж боддог. Гэтэл нахиа нь дэлгэрээд задарчихсан, тайван байдлаасаа гарчихсан үед тарьцыг суулгах нь ургахгүй байх нэг шалтгаан болдог. Тиймээс худалдаалж байгаа тарьц суулгацанд хяналт тавина. Бид жил ирэх бүрт л туршлагажиж, мод тарих ажлыг илүү үр дүнтэй болгохын тулд бүхий л асуудалд анхаарлаа хандуулж байгаа. Тухайлбал, Монгол орны газар зүйн байршил, ургамал ургалтын хугацаа баруун урдаасаа зүүн хойшоо чиглэж явагддаг. Ургамал ургалтын хугацаа эрт эхэлдэг говийн аймгуудад мод тарих ажил эхэлсэн байгаа бол хүйтэн аймгуудад бэлтгэл ажил хангагдаж байна. Энэ жил ургамал ургалт эрт эхэлж байгаа учир тарьц суулгацууд удахгүй нахиа нь задраад суулгах боломжгүй болчихно. Тэгэхээр тарьц суулгацаа зориулалтын байранд хадгалж байгаа.

**-Тарьц суулгацын үзэсгэлэн дээр хэдэн төрлийн мод авах боломжтой вэ. Мөн ургалтын хугацааны хувьд иргэд өөрсдийнхөөрөө тарихад ямар мод нь илүү тохиромжтой байдаг вэ?**

-Ургамлын мужлал, бүс бүсээрээ тухайлбал, говийн аймгуудад ямар ургамал илүү тохиромжтой ургах вэ гэдгийг анхаарна. Жишээлбэл, хайлаас, сухай гэхчилэн говийн ургамлууд маш сайн ургана. Энэ нь эргээд экологид үзүүлж байгаа нөлөөллүүд нь тодорхой хэмжээнд үр дүнтэй байдаг. Мөн суурьшил нэлээд төвлөрсөн бүсүүдэд хөрсний бүтэц, экологийн тэнцвэрт байдал тодорхой хэмжээгээр алдагдсан. Дээрээс нь өвлийн агаарын бохирдол нөлөөлдөг. Тиймээс тухайн орчны хөрс, уур амьсгалыг сайн харж байж тарих хэрэгтэй. Иргэдэд мэдлэг олгох үүднээс нэг жишээ татахад ногоон байх ёстой гээд ногоон мод л тариад байдаг. Гэтэл өвлийн агаарын бохирдол ихтэй, утааны үед шилмүүст төрлийн навчаа гээдэггүй ургамал ногоон харагддаг. Ийм төрлийн ургамлыг тарих ёстой. Гэтэл нарс модыг тарьж байгаа нь буруу. Нарс нь өвлийн улиралд ногоороод байхгүй. Гэтэл хавар болж ургамал ургалтын хугацаа маань эхлэхээр ургах гэж буй навчны нүх сүвэн дээр нь хүнд металлын бохирдол таглачихсан байдаг. Тиймээс эхлээд агаар, хөрсөө тооцоод ургамлаа зөв сонгож тарих нь чухал. Үзэсгэлэнд суурин газарт түгээмэл ургаж байгаа 20 гаруй зүйлийн бутлаг давамгай ургана. Гэхдээ сүүлийн 4, 5 жилд мод үржүүлэг аж үйлдвэрийн мэргэжлийн эрхтэй байгууллагууд өөрийн нөөц бололцоогоор интрудукц хийнэ. Интрудукц гэдэг нь харийн ургамал, элбэг дэлбэг ургамлуудыг тарималжуулах туршилт судалгааг нь хийгээд практикт нэвтрүүлж байгаа. Ховор зүйлийн ургамал болох тэсэмгийн зарим зүйлүүд агчны төрөл бидний сайн танил болоогүй ургамлууд тодорхой хэмжээгээр худалдаалагдана.

**-Үзэсгэлэнгээс суулгац тарьцаа авах нь илүү баталгаатай юу?**

-Улсын хэмжээнд нэгдсэн журмаар зохион байгуулж байгаа учраас баталгаатай. Энэ үеэр иргэдэд зөвлөгөө өгөх булан ажиллана. Аж ахуйн нэгж болон иргэн мод авахаасаа өмнө хаана, ямар мод тарих гэж байгаа болон хэрхэн арчлах талаар зөвлөгөө мэдээлэл авч болно.

**-Тодорхой зааж өгсөн газруудын талаархи мэдээлэл иргэдэд хэр хэрэгтэй вэ?**

-Нийслэлийн хувьд нийтээрээ очоод мод тарья гэхээр төвлөрсөн байршил одоогоор байхгүй. Үндэсний цэцэрлэгт хүрээлэн 970 га-д хэрэгжинэ. Түүнийх нь 170 гаруй га газрынх нь зураг төсөл хийгдчихсэн байдаг. Хоёрдугаарт иргэд тодорхой мэдлэг мэдээлэлгүй учраас буруу тарих магадлал маш өндөр гарна. Үүнээс болж модны амьдрах хувьд нь нөлөөлдөг. Тиймээс цэцэрлэгт хүрээлэн гэсэн мэргэжлийн байгууллагын өндөр стандарт барьж ажилладаг горим нь алдагдах эрсдэл гарна. Тийм учраас иргэд Үндэсний цэцэрлэгт хүрээлэн юм чинь гээд дуртай газраа тарьж болохгүй. Тухайн байрлалынхаа зураг төслийг хийнэ. Энэ нь нийгэм ахуй, эдийн засаг, хөрс, агаарын чанарын байдлын судалгааг хийсний үндсэн дээр зураг төслийг хийдэг. Төв гудамжаар төлөвлөлтгүй улиас тарьсан байна. Эдгээр нь хөгшрөөд нөхөн тайралт хийгдэхгүй байснаас үүдэн ургамлын насны ялгаа гардаг. Тэгэхээр төлөвлөлтгүйгээр мод тарина гэдэг нь буруу. Сошиалаар иргэдэд энэ талын мэдлэг мэдээллийг дэлгэрэнгүй хүргэнэ.

**-Мод тарих хүсэлтэй ч тарьц, суулгацаа сонгож чадахгүй байгаагаас эхлээд асуудалтай тулгарч байгаа иргэдэд мэдээллийг хэрхэн олгож байгаа вэ. Энэ тал дээр сургалт зохион байгуулж байгаа гэж та дээр дурьдсан?**

-Манай яамны зүгээс мэргэжлийн хүмүүс мод тарих хүсэлтэй иргэдэд зориулж, хашаагаа хэрхэн төлөвлөх, тарьц суулгацаа хэрхэн сонгох, цаашид модоо яаж арчлах талаар сургалт зохион байгуулах ажлыг дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын байгаль орчны мэргэжилтнүүдтэй хамтран нэлээд өргөн хүрээнд зохион байгуулж байна. Хамгийн эхний сургалтаа Чингэлтэй дүүргийн иргэдэд хийсэн. Иргэд маш идэвхитэй оролцож, мод тарих чиглэлийн мэдлэг, мэдээллийг нарийн цэгцтэй авлаа гэдгээ илэрхийлж байсан. Дараагийн сургалтууд маань 10, 11-нд Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвд 09-12, 13.30-16.30 цагийн хооронд болох гэж байгаа учир энэхүү сургалтад хамрагдах хүсэлтэй иргэд, аж ахуйн нэгжүүд харьяа дүүргийнхээ байгаль орчны мэргэжилтэнд хандах эсвэл Нийслэлийн байгаль орчны газарт хандсанаар суух боломжтой болох юм. Сонирхогч, мэргэжлийн бус хүмүүс гадуур энэ чиглэлийн сургалтыг их явуулдаг юм билээ. Гэхдээ 100 хувь мэдээллийг зөв өгдөггүй нь ажиглагдсан. Тиймээс салбарын яамнаас энэ чиглэлээр мэргэжлийн мэргэшсэн хүмүүсээр энэ сургалтын зохион явуулж буйгаараа онлцог. Сургалтанд сууж зөв мэдээлэл авсан иргэд мэдээллээ цааш нь зөв дамжуулаасай гэсэн зорилт хүсэлтэй байгаа.

**-Нийслэлд анхаарал сайн хандуулж байгаа юм байна гэж ойлголоо. Хөдөө орон нутагт “Мод тарих өдөр”-ийг хэрхэн зохион байгуулж, анхаарч ажиллаж байна вэ?**

-Байгаль орчин аялал жуулчлалын сайдаас аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нарт хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд ажлуудаа хэрхэн зохион байгуулж болох талаар албан даалгавар, мэргэжлийн чиглэл өгсөн. Ойн тухай хуулийн 31.1.2-т бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд мод тарих газрыг сум дүүрэг, баг хорооны Засаг дарга сонгож, цаашдын арчилгааг нь зохион байгуулахаар үүрэгжүүлсэн заалт бий. Энэ хүрээнд Засаг дарга нараа салбарын яамнаас арга зүйгээр дэмжиж ажиллаж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас аймаг нийслэл сум дүүргийнхээ хэмжээнд байгуулах гэж байгаа бичил цэцэрлэгтээ модыг ямар схемээр тарьж болох вэ гээд загвар зураг төслөө боловсруулаад хүргүүлж байгаа юм. Нэгэнт бий болгосон ногоон байгууламжийг хэрхэн арчлах ёстой вэ мэргэжлийн байгууллагатай хэрхэн хамтарч ажиллаж болох вэ гэдэг дээр Засаг дарга нарт чиглэл өгсөн байгаа.

**-Мод тарьчихаад арчилж, ургуулна гэдэг өнөөдрийн хувьд маш том асуултын тэмдэг болчихоод байгаа. Энэ бүхнийг та бүхэн шийдэхээр ажиллаж байгаа гэдгээ хэлсэн ч дан ганц яам анхаараад үр дүн гарах нь юу л бол. Тэгэхээр бүх нийтийн оролцоог нэмэгдүүлж, сэтгэлгүй байдлыг л таслан зогсоох хэрэгтэй болов уу?**

-Таны хэлж байгаатай санал нэг байна. Мод тарихаас эхлээд байгаль дэлхийгээ хамгаалах ажлыг дан ганц албаныхан хийдэг юм шиг л ойлголт өнөөдөр бий болчихож. Бүх нийтээр мод тарих өдөр өөрийн биеэр мод тарих боломжгүй иргэн бүр нэг модыг арчилж хамгаалах зардлыг хандивлана гэсэн хуулийн заалт байдаг. Өөрийн биеэр мод тарих боломжгүй юм уу, газаргүй иргэд олон байгаа. Тэр хүмүүсийн мөнгийг хуримтлуулсан мөнгөөр талбайг арчлах боломжтой гэж би хувьдаа үздэг. Харамсалтай нь энэ хэрэгжих эрхзүйн орчин байхгүй байгаагаас эхлээд маш олон асуудал тулгарч байна. Тэгэхээр хаана, хаанаа сэтгэл гаргаж, эх дэлхийгээ ногоорууулах буянтай үйлсэд хандаасай гэж л хүсэх байна.

**-Сайн дураараа мод тарих гэж байгаа иргэдэд хандаж мэргэжлийн зөвлөгөө өгнө үү?**

-Манай Монгол орны уур амьсгалтай уялдуулаад ногоон байгууламжийн төлөвлөлт маш сонирхолтой байдаг. Тэгэхээр анхан шатны сургалтаар жижиг мод, монос гэхчилэнг тарихаар таван жилийн дараа ямар хэмжээтэй болсон байх вэ гэдгээ төсөөлж төлөвлөөд модоо тарих ёстой. Жишээлбэл, орон сууцанд амьдардаг айл цонхныхоо доор улиас мод тарьчихаад тун удахгүй таван жилийн дараа хоёр гурван айлын цонхыг хааж ургах жишээтэй. Энэ нь буруу төлөвлөлт. Мөн цонхныхоо доор ялаа, шумуул, хортон шавж цуглуулдаг үнэртэй жимсний мод тарьчихвал хэцүү. Нөгөө талаас хүүхдийн тоглодог тоглоомын талбайд өргөстэй мод тарьвал энэ нь бас буруу. Иймээс нэгдүгээрт нь модоо зөв сонгох, төлөвлөх хэрэгтэй. Уг нь манайд “Улирлын төлөвлөлт” гэсэн сонирхолтой төлөвлөлт байх ёстой байдаг юм. Дөрвөн улирлын өнгө нь ямар байх вэ гэхчилэн. Модлог ургамал нь ургамал ургалтынхаа хугацаанд янз бүрээр цэцэглэдэг. Цэцгээрээ гоё ургамал байвал эхлээд нохойн хошуу нь дараа нь гэх мэтээр цэцэглэх насыг нь хүртэл хооронд нь уялдуулаад төлөвлөвөл зунжингаа цэцэгтэй байх боломжтой. Иргэдэд энэ талын мэдлэг мэдээлэл маш их хэрэгтэй байгаа нь анзаарагдсан. Өвлийн ногоон байгууламж маань үхмэл байдалтай байдаг. Энэ үед хамгийн их механик гэмтлийг авдаг. Тиймээс өвлийн гэмтэл зуны арчилгааг үр дүнтэй байлгахын тулд хашаа хамгаалалттай газар байрлалаа зөв сонгох ёстой. Жишээлбэл, нийслэл аймгийн төвүүдэд гэхчилэн суурьшлын бүс хамгийн тохиромжтой. Эмнэлэг сургууль цэцэрлэгийн хашаа илүү тохиромжтой. Яагаад гэхээр эдгээр газруудад иргэд идэвхитэй амьдралыг өрнүүлж байдаг учраас хяналт тавих боломжтой гэсэн үг. Нэг жишээ дурьдахад, улсын төсвийн хөрөнгөөс мөнгө аваад арчилгаа үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгжийн ажилд иргэд тусладаг. Гэтэл дахин төлөвлөлтөөр нөгөө тарьсан модыг нь өөрчлөх ч гэдэг юмуу иймэрхүү байдлаас үүдэн иргэдийн мод тарих идэвхийг бууруулж байдаг. Нөгөө талаас бид та бүхний тарьсан модыг арчилж өгье гээд хандив мөнгийг нь цуглуулдаг. Гэтэл эргээд арчилгааг нь хийхгүй байх гэхчилэнгээр иргэдийн идэвхид сөргөөр нөлөөлсөн асуудал гаргадаг.

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

## Ногоон технологийн цэцэрлэг урсгал зардлыг 75 хувь хэмнэнэ

Үндэсний компаниуд Монгол орны нөхцөлд тохирсон ногоон цэцэрлэгийн барилгын зураг төслийг иж бүрнээр нь боловсруулж Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүлээлгэж өглөө. Засгийн газар, нийслэлийн Засаг даргын зүгээс дэвшүүлсэн зорилтын хүрээнд Сонгинохайрхан дүүргийн XXV хороонд 125 хүүхдийн жишиг ногоон цэцэрлэг барихаар шийдвэрлэсэн билээ. Ногоон цэцэрлэгийн урьдчилсан зураг төсөл, технологийн шийдлийн үнэлгээг Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллага, Солонгосын ногоон хөгжлийн төв хамтран боловсруулжээ. Улмаар зураг төслийг “Монголын ногоон барилгын хүрээлэн”, “Бюлдингс техноложи” компаниудын хамтарсан консорциум гүйцэтгэсэн байна. Тус цэцэрлэг нь эрчим хүч, усны хэмнэлттэйгээс гадна хүүхдийн эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй гэх мэт олон давуу талтай бөгөөд цэцэрлэгийн урсгал зардал жирийн цэцэрлэгтэй харьцуулахад 75 хувиар бага байна гэсэн тооцоог судалгааны багийнхан гаргасан байна. Барилгын дээвэрт суурилуулсан 128 ширхэг нарнаас эрчим хүч хуримтлуулах хавтангийн тусламжтайгаар цахилгааны хэрэглээний 60 орчим хувийг ногоон технологийн тусламжтай үйлдвэрлэж, өөрөө өөрийгөө хангах чадвартай аж. Ногоон цэцэрлэг байгуулах төсөл 2015 оны арваннэгдүгээр сараас эхэлж, өчигдөр зураг төслөө эцсийн байдлаар гаргасан бол барилгын ажил ирэх онд эхлэх боломжтой гэдгийг ажлын хэсгийнхэн өглөө.

## Олон улсын эко сургууль хөтөлбөрийн “Хүрэл гэрэгэ”-ийн эзэд тодров

Олон улсын эко сургууль хөтөлбөрийн “Хүрэл гэрэгэ” гардуулах арга хэмжээ Монголын Уран зургийн галарейд боллоо. Энэхүү үйл ажиллагааг Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр БОАЖЯ, БСШУСЯ-тай хамтран хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжлийн боловсрол” төслийн хүрээнд олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй хамтран зохион байгуулсан юм. Энэ үеэр хөдөө, орон нутаг болон нийслэлийн 41 сургууль "Хүрэл гэрэгэ”-ийн болзол ханган гэрэгэг гардан авлаа. Тус үйл ажиллагааг нээж, БОАЖ-ын дэд сайд Ц.Батбаяр, БСШУСЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтын ажиллагааны захирал, Ерөнхий консул Габрелла Спирли нар




үг хэллээ. “Хүрэл гэрэгэ”-ийн болзол хангасан ерөнхий боловсролын сургуулиудыг урамшуулж, тэдний амжилтыг олон нийтэд сурталчлан таниулах, харилцан туршлага солилцох боломж олгох, байгальд ээлтэй амьдралын хэв маягийг хүүхэд залууст төлөвшүүлэх зэрэг нь тус хөтөлбөрийн зорилго юм. Мөн цаашид амжилтаа ахиулан “Мөнгөн гэрэгэ”, “Ногоон туг” олон улсын эко шошгын болзол хангаж, амжилтаа бататган хадгалахад нь мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургуулиудтай хамтран ажиллахаар болжээ. Олон улсын эко сургууль хөтөлбөрийг 2007 оноос эхлэн Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр хот хөдөөгийн 65 сургууль амжилттайтуршинхэрэгжүүлж, 2011 оноос Дэлхийн байгаль орчны боловсролын сангийн албан ёсны эрхтэйгээр хамрах хүрээгээ өргөжүүлэн ажиллаж байна. Одоогоор энэхүү хөтөлбөрийн сүлжээнд орон нутаг, нийслэлийн нийт 200 гаруй ерөнхий боловсролын сургуулиуд хамрагдсан бөгөөд энэ хөтөлбөрт дэлхийн 64 орны 49 мянга гаруй сургуулиуд нэгдэн орсон байна.

АЯНЫ БОГЦ

# Говийн хүү ЭРГЭЖ ирлээ

Н.БАТЗАЯА

Юуны өмнө энэ удаагийн томилолт эцгээ гэсэн үрийн сэтгэл, бие биеэ хайрлан хүндэтгэх ах, дүүсийн халуун дулаан энерги дунд нэгэн ухаарлыг олж, уянгаар хөглөгдсөн томилолт байсныг онцолъё. Оройны 16:00 цагаас хойш сонины редакцид "халуухан" уур амьсгал өрнөнө. Учир нь сэтгүүлчдийн өдрийн турш бэлтгэсэн материал олон шат дамжлагыг дамжин уншигчийн гарт хүрэхэд бэлэн болох хариуцлагатай үе. Энэ л цаг үед Хариуцлагатай нарийн бичгийн дарга маань "Маргааш өглөөний 09:00 цагт "Зохиомж" дээд сургуулийн захирал, кино найруулагч Б.Цогтбаяртай хамт томилолтод яваарай" гэх үүрэг өгөх нь тэр. Ажил тарах цаг дөхөж хүн бүр урдах ажлаа яаравчлан хийж буй тул даргаасаа илүү зүйлийг лавлан асуусангүй. Ингээд маргааш өглөө нь эртлэн босч, болзсон газраа зорилоо. Явах замдаа өмнө нь телевиз, сонинд өгсөн ярилцлага, хийсэн киног нь л үзэж, харснаас биш нүүр тулан уулзаж, ярилцаж байгаагүй тул Монголын үндэсний кино академийн тэргүүн, кино найруулагч Б.Цогтбаяр гуайг өөрийнхөөрөө төсөөлөн басхүү тийм "том" хүнтэй аяны дөрөө нийлэх болсондоо "эмээн" явлаа. Ийнхүү ямар шалтгааны улмаас хаашаа томилолтод явахаа мэдэхгүй явсаар болзсон цагтаа "Зохиомж" дээд сургууль дээр ирэв. Тус сургууль гадна тохижилтоосоо эхлээд л анхаарал татав. Гадна талын хананд урлагийн гурван баганыг урласан нь урлагийн сургууль гэдгийг илтгэнэ. Сургуулийн хаалгаар ормогц л хананд Монголын ардын хувьсгалын үеийн түүхэн агшинг өгүүлэх гэрэл зургийг байрлуулжээ. Харин багахан хэмжээний музей гэхээр тэрхүү түүхийн дурсгалт зүйлсийг энд дурьдалгүй эрхэм уншигч танд тус сургуулиар зочлон сонирхох боломжийг үлдээе. Ингээд кино найруулагч Б.Цогтбаяр гуайтай уулзаж, ярилцвал эрч хүчээр дүүрэн, алиа хошин зантай, хүнийг их бага хэмээн ялгалгүй харьцдаг нэгэн байлаа. "Зохиомж" дээд сургуулийн III давхарт байрлах өрөө нь тэр чигтээ өөрийнх нь амьдрал, уран бүтээлийн архив хэмээн хэлж болохоор. Урлагийн хүн болоод ч тэр үү өрөөнд нь түүхэн агшинг өгүүлэх ховор нандин гэрэл зураг, том шагнал, уран баримал энд тэндгүй харагдана. Түүний ажлын ширээний ард талын хананд байрлах хар үстэй, цайвар саарал өнгийн сорочкон цамц өмссөн 60 гаруй насны нэгэн эрэгтэйг ажлын ширээнийхээ ард тухлан сууж, баруун гартаа тамхи барьж, үл ялиг бодлогоширон буйгаар дүрсэлсэн нэгэн уран зураг нүдэнд шууд өртөж, хэн болох талаар асуулаа. Харцнаас нь ухаарал мэдрэгдсэн энэ буянтай буурал Б.Цогтбаяр гуайн аав гэнэ. Ингэж аян замын учиг сая тайлагдав. Б.Цогтбаяр гуай Монголын ард түмэнд Хянан шалгахын жижиг Бямбаа нэрээрээ алдаршсан Монгол Улсын Гавьяат Эдийн засагч Долгорын Бямбаагийн ууган хүү нь байв. Тэрээр Өмнөговь аймгийн Номгон суманд төрсөн бөгөөд тус аймгийн IV сургууль МУГЭЗ Д.Бямбаагийн нэрэмжит болж байгаа аж. Энэхүү баярт үйл явдалд оролцохоор үр хүүхэд, ах дүүс нь өмнийн цэнхэр говийн зүг хүлгийн жолоо залж байгаа нь энэ буй заа. Ингээд явах газар хол, холын замд гарах хүмүүст ч бэлдэх зүйл их тул тэр бүхнийг базаасаар 14:00 цагтай уралдан аяны жолоо өргөлөө.

Аавын нутаг ивээж угтлаа
Аяны шувууд тэнгэр цуулаад
Алсын нутгаа зориод ирнэ ээ
Аргил хоолой сэтгэлд үгүйлэгдээд

Аавaa би санаад л байна аа хэмээн Монголын ард түмний сэтгэл зүрхэнд хоногшсон дууны шүлгийн мөр шиг энэ өдөр хамгийн ихээр аавыгаа санан дурсаж, сэтгэл зүрх нь гэгэлзэн яваа хүмүүс бол түүний үр хүүхэд билээ. Тиймээс хүрэх газар хол, угтан ирэх зам урт учир ууган хүү Б.Цогтбаяр, түүний гэргий МУГБ Д.Энхжин, ууган хүү Ц.Энхцогт, нагац эгч Л.Нэргүй нартай дурсамж хөглөн явав. Гавьяат эдийн засагч Д.Бямбаа 1921 онд Өмнөговь аймгийн Номгон сумын Хармагтай багийн нутаг, Буурын хярын "Шил хуудас" гэдэг газарт Долгорын хоёрдугаар хөвгүүн болон мэндэлжээ. Тэрээр, дөрвөн настай байхаасаа л нутгийнхаа бичиг номтой өндөр Пүрэв гэдэг хүнд шавь орж, улмаар сумынхаа захиргаанд бичээчээр ажилласан байна. Бага байхын эрдэм ухаанд гарамгай байсан тул Номгон сумынхаа бичиг үсгийн түр сургуульд хоёрхон жил сураад л аймгийн захиргаанд бичиг хувилагчаар ажилласан гэнэ. МУИС-ийн Эдийн засгийн дээд сургуулийг улаан дипломтой дүүргэсэн тэрээр Намын дээд сургуульд ч суралцаж төгсгөжээ. Харин амьдралынх нь салшгүй нэгэн хэсэг болсон хянан шалгах байгууллагад 1952 оноос хойш 40 гаруй жил ажиллахдаа олон зуун албан байгууллагад хяналт, шалгалт явуулж, хэдэн зуун сая төгрөгийн зөрчил, хохирол илрүүлэн, түүнийгээ нөхөн барагдуулах, улсыг хохиролгүй болгох ажил хийсэн хэмээн мэргэжил нэгтнүүд нь дурсан ярих юм билээ. Увс аймгийн Хяргас сумын харьяат Хасагийн Хандсүрэн хэмээх бүсгүйтэй ханилан Цолмон, Шинэцолмон, Алимаа, Цогтбаяр, Хосбаяр нарын таван сайхан үр хүүхдийн эцэг, эх болжээ. Ууган хүү Б.Цогтбаяр "Миний ээж 85 насыг зооглож буй сайхан эмэгтэй бий. Би ээжийнхээ нэг зан чанарыг ихэд үнэлдэг юм. Намайг хичээлээ тараад ирэхэд ээж минь гэрийнхээ тавилгуудын байрлалыг өөрчилчихсөн суудагсан. Ээж минь шинэ зүйл худалдан авч, гэрээ чимэх дуртай хүн. Миний ээж огт зүгээр суудаггүй маш их хөдөлмөрч, сайхан эмэгтэй" хэмээн өгүүлэв. Би түүнээс "Хүн бүрийн чин хүсэл эцэг, эхийнхээ ачийг хариулах. Та аавынхаа ачийг хариулж чадав уу" гэж асуухад, "Энэ хорвоо дээр эцэг, эхийнхээ ачийг ингэвэл, тэгвэл хариулна гэсэн тогтсон зүйл үгүй шүү дээ. Мөр бүтэн явж, эцгийнхээ нэрийг муугаар дуудуулахгүй байх нь л чухал. Би аавынхаа ачийг хариулж яваа л гэж боддог. Дэлхийн анхны нэр хүндтэй сургууль болох Москвагийн кино урлагийн дээд сургуулийг 1988 онд төгссөн. Миний бүтээлүүдийн анхны үзэгчдийн нэг нь аав минь байдаг байсан. "За аав ямар болж" гэж асуухад минь яах вэ боломжийн, зүгээр л гэдэгсэн.

Монголын ард түмэн кино найруулагч Б.Цогтбаярыг "Дээд хэмжээ", "Их говийн жонон-Гамлет, "Хубилай хааны зарлиг", "Уучил", "Луйвар", "Богд хаан", "Харанхуй хад" гээд олон сайхан дэлгэцийн бүтээлээр нь андахгүй сайн мэднэ. Үр хүүхэд нь мөр бүтэн явааг харах эцэг, эхчүүдийн хувьд хамгийн том жаргал байдаг биз ээ. Түүнээс илүү тэднийг баярлуулах зүйл үгүй мэт. Ийнхүү сэтгэлийн гүнд нь мөнхөд хадгалагдсан нандин дурсамжийн хэлхээг тээн явтал аль хэдийнэ өмнийн говийн нутаг дөхсөн байв. Сайхан дурсамж, яриа дэлгэсэн болоод тэр үү замын холыг ажралгүй говийн улаан наран шингэхтэй зэрэгцэн Өмнөговь аймгийн Даланзадгад сумын бараа харагдах нь тэр. "Хүү минь аавынхаа нутагт ирлээ" гэсэн мэт говийн салхи хацар зөөлөн илбэж, Гурван сайхан уул нь ирэхгүй удсан хүүхдээ угтан тосох эцэг шиг алсаас бараагаа тодруулан байлаа. Уг нь хаврын цагт говийн тэнгэр шороон шуурга тавихгүй байх нь ховор үзэгдэл аж. Ингээд бид Өмнөговь аймгийн Даланзадгад суманд суух Д.Бямбаа гуайн ах, дүүтэй уулзаж, маргааш болох үйл ажиллагааны хөтөлбөрийг танилцуулсаны дараа IV сургууль руу очив. Нээлтийн үйл ажиллагаанд зориулж, тус сургуулийн хамт олон эртнээс сэтгэл гарган бэлдсэн нь илэрхий байлаа. Учир нь сургуулийн төв хаалганы дээр байрлах урсдаг самбар дээр "МУГЭЗ Д.Бямбаагийн нэрэмжит IV сургууль" хэмээн бичжээ. Цаг аль хэдийнэ оройн 23:00 цаг өнгөрч, сургуулийн удирдлагууд гэртээ харьсан тул биднийг жижүүр багш нь угтан авсан юм.


Зүүн гар талаас Б.Цолмон, Б.Цогтбаяр, Б.Хосбаяр, Ц.Энхцогт нар эцгийнхээ, өвөөгийнхөө буурин дээр







## IV сургууль Монгол Улсын Гавьяат Эдийн Засагч Долгорын Бямбаагийн нэрэмжит болов

2017 оны дөрөвдүгээр сарын 25. Өглөөний 09:00 цаг. Сургуулийн коридорт жингэнэх завсарлагааны хонх, сурагчийн дүрэмт хувцсаар гангаран энд тэндгүй дэгэж дэрвэн гүйлдэх сурагчдыг харсан хэн ч болов гэнэн томоогүй хүүхэд насаа дурсахгүй байхын аргагүй. Тус сургуулийн хананд олон толь байх бөгөөд дээр нь сурагчдад урам, ухаарал хайрласан мэргэн үгсийг бичсэн нь тэдэнд хичээл номдоо шамдан суралцах итгэл найдвар төрүүлдэг мэт санагдсан. Өглөөний 09:30 цагт Өмнөговь аймгийн Даланзадгад сумын IV сургуулийн захирал, сургалтын менежер, багш нартай уулзаж, нээлтийн үйл ажиллагааны хөтөлбөр болон цаашдын хамтын үйл ажиллагааны талаар санал солилцлоо. Энэ үеэр тус сургуулийн захирал Ц.Батцэнгэл "Манай сургууль МУГЭЗ Д.Бямбаагийн нэрэмжит болж буйд бид маш их баяртай байна. МУГЭЗ Д.Бямбаагийн нэрэмжит болсноор манай сургуульд маш олон боломж нээгдсэн. Тухайлбал, хамтын ажиллагааны гэрээний хүрээнд, Д.Бямбаа гуайн үр хүүхдүүд жил бүр дөрвөн сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг манай сургуульд хийхээр боллоо. Түүнээс гадна жил бүр нэг сурагчийг сонгон Олон Улсын Бизнес Технологийн "Зохиомж" дээд сургуульд дөрвөн жил үнэ төлбөргүй суралцуулахаар болсон. Бид үүнд маш их баяртай байгаа" гэв. Тус сургууль нь 2007 онд байгуулагдсан бөгөөд үйл ажиллагаандаа цахим хэлбэрийг бүрэн нэвтрүүлсэн гэнэ. Мөн IV сургууль аймаг, орон нутагтаа бүжгийн спортоороо алдартай. Уг сургуульд одоогийн байдлаар 60 гаруй хүүхэд тогтмол бүжгийн дугуйланд хамрагддаг бөгөөд багш нар нь манай сургуульд бүжиглэж чаддаггүй сурагч байдаггүй хэмээж байлаа. Үүний дараа нээлтийн ажиллагааны бэлтгэл ажилдаа шамдан орж, юун түрүүнд сургуулийн төв хаалганы дээд талд байрлах хуучин хаягийг авч, МУГЭЗ Д.Бямбаагийн нэрэмжит IV сургууль гэх шинэ хаягаар солив. Нээлтийн үйл ажиллагаанд Өмнөговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Х. Сугир, Өмнөговь аймгийн Засаг даргын орлогч Х.Батболд, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Ч.Энхцацрал, IV сургуулийн захирал Ц.Батцэнгэл, гавьяат эдийн засагч Д.Бямбаагийн үр хүүхэд, ах дүү, төрөл төрөгсөд болон IV сургуулийн багш, сурагчид, эцэг эхийн төлөөлөл оролцлоо. Тус үйл ажиллагааг нээж, Өмнөговь аймгийн Засаг даргын орлогч Х.Батболд "Нар гийсэн сайхан өдөр Өмнөговь аймгийн түүхийн нэгэн хуудас болсон та бүхэнд баярлалаа. IV сургууль МУГЭЗ Д.Бямбаа агсны нэрэмжит болсноор сургуулийн хамт олныг өндөр хариуцлага хүлээж байна. Хийж бүтээсэн ажлынхаа амжилтыг улам бататган, хүүхэд багачуудыг амьдрах ухаан, эрүүл аж төрөх ёсонд сурган, авьяас чадварыг нээн хөгжүүлэх үйлсэд тань их амжилт хүсье" хэмээсэн. Түүхийн нэгэн хуудсанд тодоос тод мөнхрөн үлдэх баярт үйл явдалд хүрэлцэн ирсэн хүндэт зочид үг хэлсний дараа гавьяат эдийн засагч Д.Бямбаа агсны үр хүүхэд болон албаны хүмүүс тууз хайчиллаа. Энэ үеэр бидний хүсэл биеллээ хэмээн үр хүүхэд, ах дүү нар нь нүдэндээ нулимс цийлэгнүүлэн дурсан ярив. Учир нь МУГЭЗ Д.Бямбаа хүүхэд, багачуудын эрдэм мэдлэгт шамдан суралцахыг үргэлж дэмждэг нэгэн байжээ. Тиймээс ч ах, дүү, нутаг орныхоо хүүхдүүдэд эрдэм номын мөр хөөх гүүр нь болж байсан гэнэ. Ах, дүүсийнх нь хүүхдүүдийн дунд Д.Бямбаа агсны гэрт сууж, их, дээд сургуульд суралцан амьдрал хэмээх их далайд хөл тавиагүй нэгэн ховор аж. Энэ талаар зээ дүү Л.Нэргүй "Одоо бодоход ах минь эрдмийн их уурхай байжээ. Гэрт нь ирсэн хүүхэд бүрийг хүний, өөрийн гэж ялгахгүй эрдэм сур, хүнд тусал гэдэг хоёр сургаалийг байнга л айлдана. Манай ах дүүсийн олон хүүхдүүд ахынд маань амьдарч, сургуулиа амжилттай дүүргэсэн. Одоо мянга мянган хүүхэд ахын минь нэрэмжит сургуулиар дамжин эрдмийн их далайд хөл тавих нь" хэмээн дурсан ярилаа. Үнэхээр түүний хэлсэнчлэн мянга мянган хүүхэд багачууд МУГЭЗ Д.Бямбаагаар овоглон эрдэм ухаанд шамдан суралцана. Тус сургуулийг төгссөн хүүхэд бүрийн гэрчилгээн дээр МУГЭЗ Д.Бямбаагийн нэрэмжит IV сургууль хэмээх эрхэм алдар мөнхөд оршино. Хэдийгээр бага наснаасаа эхлэн улс орны нэр хүндтэй ажил албанд тохоогдон төрсөн нутгаасаа гарч, Улаанбаатар хотод аж төрсөн ч түүний улс эх орныхоо төлөө амь бие, сэтгэл зүрхээ зориулан байж хийж бүтээсэн бүхэн нь үр хүүхэд, хойч үеэр нь дамжуулан эх нутагтаа мөнхөд мандан цэцэглэх нь. Хүн өтлөхийн цагт унасан, төрсөн газартаа ирдэг гэдэг энэ буй заа. Нээлтийн үйл ажиллагаа Оюуны мэлмий IV сургуулийн спорт зааланд үргэлжилсэн. Тус сургуулийн авьяаслаг хүүхэд, багачууд энэхүү баярт үйл явдлыг хуваалцан ардын бүжгээс эхлээд орчин үеийн бүжиг, хамтлаг дуу, гоцлол дуугаар ирсэн зочдод мэндчилгээ дэвшүүлсэн. Манай сургуульд бүжиглэж чаддаггүй хүүхэд байхгүй хэмээн Ц.Батцэнгэл захирлын хэлсэн нь санаанд бууж суулаа. Авьяаслаг сурагчдад зориулан Д.Бямбаа агсны үр хүүхдүүд 30 хос бүжгийн гутал бэлэглэсэн нь баяр дээр баяр нэмсэн үйл явдал болсон. Бүжигчин хүнд гутал хамгийн чухал гэдгийг ч тус сургуулийн авьяаслаг багачууд онцолсон. Баярт үйл явдал үүгээр дуусcангүй. Тус сургуулийн 13 багш, ажилтан, хоёр сурагчийг "Соёлын тэргүүний ажилтан", "Боловсролын тэргүүний ажилтан", "Хөдөлмөрийн алдар", "Тэргүүний сурагч" зэрэг цол тэмдгээр шагнав.

Энэ өдрийн үйл ажиллагааны арын албаны ажлыг нуглан ерөнхий зохион байгуулагчаар ажиллаж буй нэгэн бол Д.Бямбаа агсны том хүү Б.Цогтбаярын гэргий МУГБ Д.Энхжин билээ. Арван жилийн нэг ангийн хоёр амьдралаа холбож, олон сайхан хүүхэд төрүүлэн өсгөж, хүмүүжүүлжээ. Д.Энхжин багш хадам аавaараа маш их бахархдаг тухайгаа бидэнтэй ийн хуваалцсан. Тэрбээр "Аав минь маш эртэч, их уншдаг, хөдөлмөрч үлгэр дуурайл болсон сайхан хүн байсан. Мөн хүнтэй их сайхан мэндэлнэ. Би уг нь гэр бүлийнх нь гишүүн шүү дээ. Гэтэл надтай өдөрт хэдэн ч удаа таарсан хамаагүй мэндэлж, гэр орон, үр хүүхдүүдийн минь талаар асууж, үргэлж анхаарал тавьдаг байж билээ. Миний аав эрдэнэ мэт сайхан хүн байсан" хэмээв.

## Аавын минь бууц

Говийн шаргал наран алсаас улаан шаргал өнгөөр туяаран мандаж, тэртээ харагдах уул толгод нь нүд баясгаж, зөөлөн салхи нь сэтгэл дүүргэсэн нэгэн сайхан өглөө бид Д.Бямбаа агсны төрсөн газар болох Номгон сумын Хармагтай багийн нутаг, Буурын хярын "Шил хуудас"-ыг зорилоо. Аймгийн төвөөс зүүн урагш 70 гаруй км шороон замаар давхисаар Буурын хярын "Шил хуудас"-т ирэв. Эргэн тойрон говийн толгодоор хүрээлэгдсэн нөмөр нөөлөг бүхий энэ л газарт гавьяат эдийн засагч Д.Бямбаа төрж, өсчээ. Бид нэгэн зүйлд ихэд бэлгэшээсэн нь Д.Бямбаа агсны бууцыг Өмнөговь аймгийн Манлай сумын харьяат Монгол Улсын арслан Г.Дэмүүлийн дунд охин Отгонжав гэр бүлээрээ 28 жил сахин амьдарч буй явдал байлаа. Гэр бүл болсон цагаасаа эхлэн Буурын хярын "Шил хуудас"-ыг тойрон нутаглаж ирсэн тухайгаа гэрийн эзэн А.Нэргүй бидэнд хуучилсан. Тэрбээр ирсэн зочид болгоноо уриалгахан гэгч нь угтаж, төмөр утсаар урласан оньсон тоглоомоор оюун ухаанаа сорихыг урина. Түүний тоглоомонд өөрийнх нь төмөр утсаар урласан оньсон тоглоомуудаас гадна энд тэндээс цуглуулсан тоглоом ч байсан. Ирсэн гийчдээ хөгжөөн, сонин сайхан яриа дэлгэн суух эгэл жирийн монгол малчин айлын гэргий эртний сайхан заншлаараа биднийг борцтой сүүтэй цайгаар дайлсан нь замын ядаргааг тайлсан. А.Нэргүйн гэрийн хойд талд хоёр шон байрлах бөгөөд тэднийг анх нүүж ирэхэд нь гэрийн буйр байжээ. Аавынхаа төрж өссөн гэрийн буйран дээр хөрвөөж, эцгээ санасан сэтгэлээ тэд дэвтээсэн. Аавынхаа буцан дээр хөрвөөвөл бүх л муу муухай зүйлс үргэдэг хэмээн өвөг дээдэс ярьдаг билээ. Эцгийн минь өсч төрсөн газрын бууцны үнэр, уул, толгод нь хүртэл сэтгэлд ойрхон байна хэмээн ярих кино найруулагч Б.Цогтбаяр нулимс дуслуулан ийн ярив. "Аймгийн төвөөс гарсан цагаас эхлээд л сэтгэл ихэд догдолж явлаа. Яг л аавтайгаа дахин уулзах гэж буй мэт сэтгэгдэл төрж, сэтгэл маш их хөдөлсөн. Аавынхаа бууцан дээр хөрвөөж байхад аавтайгаа өнгөрүүлсэн бүх л дурсамж минь киноны кадр мэт урсан өнгөрсөн. Тэр богинохон хугацаанд их зүйлийг бодсон" хэмээсэн. Харин бага хүү Б.Хосбаяр нь "Аавынхаа төрсөн бууцан дээр ирэхэд сэтгэл маш сайхан байна. Аав минь биднийг сайн сайхан өсгөж хүмүүжүүлсэн. Хатуу ширүүн үг хэлэхээс илүү өөрөөрөө үлгэр дуурайлал үзүүлдэг байлаа. Бидэнд үргэлж хүнд туслаж байхыг захиж, сургана. Их хөдөлмөрч хүн. Бид аавынхаа ажил хэргийг үргэлжлүүлэн IV сургуулийн үйл ажиллагааг дэмжин ажиллана. Цаашид хамтын ажиллагаатай байна" гэв. Ийнхүү бид бүйлс цэцэглэсэн хөндийгөөр давхисаар Өмнөговь аймгийн төвд буцан ирж, IV сургуулийн захирал болон нийгмийн ажилтан, багш нартай уулзаж тэдний санал хүсэлтийг сонссон юм. Тэд гадаадын аль нэг улсад багш солилцооны хөтөлбөрт хамрагдах, төгөлдөр хуур, цахилгаан хөгжим авах, сургалтын хэрэглэгдэхүүнтэй болох, чийрэгжүүлэх танхим байгуулах хүсэлтэй байгаагаа Д.Бямбаа агсны үр хүүхдүүдэд уламжилсан. Энэ үеэр бага хүү Б.Хосбаяр "Багш нарын саналыг хүлээж авлаа. Бид сургуулийн цаашдын үйл ажиллагаанд тодорхой хөрөнгө оруулна. Мөн жил бүр амьжиргааны төвшин доогуур хүүхдүүдэд хичээлийн хэрэглэл бэлэглэнэ. Бидний нэн тэргүүнд ирэх намар сургуулийн урд аавынхаа хөшөөг босгохоор төлөвлөж байна" гэсэн юм. Мөн Д.Бямбаа агсны том охин Б.Цолмон өөрийн зүгээс сургуулийн багш нарыг гадаадад багш солилцооны хөтөлбөрт хамруулах ажилд онцгойлон анхаарч ажиллана гэдгээ илэрхийлсэн. Д. Бямбаа агсны дүү Чулуунтогоо, Болд, Алтангэрэл, Цэрэнпагма нар сургуулийн үйл ажиллагааг дэмжин цаашид өргөжүүлэн хамтран ажиллах талаар тодорхой саналууд дэвшүүллээ. Дөрөв дүгээр сургуулийн хичээлийн байр, дотуур байртай танилцаж, сурагчдын цайны газарт үдэлтийн амтат зоог барьсны дараа тус сургуулийн ахлах менежер И.Чингэрэл, бага боловсролын менежер Ш.Мөнх-Эрдэнэ, нийгмийн ажилтан Е.Цэцгээ болон бусад багш нар биднийг үдсэн юм. Ийнхүү бид Улаанбаатар хотын зүг хүлгийн жолоо заллаа.

Хүн энэ хорвоод мөнх бус оршдог ч хүний хийж бүтээсэн бүхэн үр хойчоороо дамжин мөнхөд оршдогийн илрэл энэ буй заа. Сайхан эцгийн сайн үрс, ач, зээ, ахан дүүс түүний хүүхэд, багачуудыг эрдэм номын замд хөтлөн оруулах чин хүслийг нь өртөөлөн цаашид ч тасралтгүй үргэлжлүүлнэ. Биднийг явах үед өмнийн цэнхэр говь сайхан айлаараа угтсан шигээ зөөлөн салхи нь сэвшин үлээн үдэж билээ.

# NO STRESS

ОНЦЛОХ ГЭРЭЛ ЗУРАГ

## “Адидас гуталтай эмэгтэйн олдвор”-ыг олон НИЙТЭД ДЭЛГЭЛЭЭ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 18
Шөнө 2

Нөгөөдөр
Өдөр 11
Шөнө 4

### Өдрийн зурхай

**ХАВРЫН АДАГ ХӨХ ЛУУ САРЫН ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН ХОНЬ ӨДӨР**

**Наран ургах, шингэх:** 05.28-20.16
**Үс засуулбал:** Жаргал ирнэ



*Тухайн өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, эрдэнийг гадагш өгөх, мал худалдан авах, мал түгээх, сахил санваар авах, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Ханууp, төөнүүр хийлгэх, балгадын сууpь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал ирнэ.*

ДУУЛГАХ СОНИН

### 25 кино шилдгийн төлөө өрсөлдөнө

“Cinema Awards” Монголын кино урлагийн дээд шагнал гардуулах наадмын хоёр дахь үе шат эхэллээ. Тус наадамд 2016 онд нээлтээ хийсэн нийт 46 киноноос шилдэг 25 киног олон нийтийн санал асуулгаар шалгаруулсан юм. Шилдэг 25 киноноос кино урлагийн зөвлөлийн шүүгчдийн саналаар дараах 12 киног 15 номинацид өрсөлдүүлэхээр болсон байна. Тухайлбал, “Өртөө”, “Бүү март”, “Ээж”, “Атганд үлдсэн эрдэнэ”, “Итгэл”, “Үргээлэг-2”, “Шүүдэр дундуур”, “Аз жаргал”, “Цагаан хадаг”, “Lovers”, “Өвлийн тууж”, “6 дахь хүсэл” зэрэг кинонууд багтжээ. Энэхүү наадам нь Монголын уран бүтээлчдийн бүтээлийг дэлхийд таниулах, шилдэг кино бүтээхэд дэм болох, оюуны боловсролд нөлөөлөх хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой аж.

### С.Гантогоо “Тарагтай боов” нэвтрүүлэгт уригджээ

“Channel 11” телевизээс “Тарагтай боов” ярилцлагын нэвтрүүлгийг бэлтгэн хүргэдэг билээ. Тус нэвтрүүлгийн энэ удаагийн дугаарт “Монтант” /Multicultural Transnational Chorus/ урлагийн байгууллагын дуучин, “Яг түүн шиг” шоуны оролцогч С.Гантогоо уригдсан байна. “Тарагтай боов” нэвтрүүлгийг дуучин А.Хишигдалай хөтлөн олон нийтэд хүргэдэг бөгөөд хөтлөгч, оролцогч нар “Яг түүн шиг” шоуны өрсөлдөгчид юм. С.Гантогоогийн оролцсон “Тарагтай боов” нэвтрүүлэг тун удахгүй цацагдах ажээ.



ОДДЫН АМЬДРАЛ

### КУРТ РАССЕЛ, ГОЛДИ ХОУН нар “Алдарын од”-той болов




Холливудын нэрт жүжигчин Курт Рассел, Голди Хоун нар Нью Йорк хотноо байрлах холливудын гудамжинд өөрсдийн гэсэн “Алдарын од”-той болсон талаар “www.dailymail.co.uk” сайт мэдээлэв. Тэдний ёслолын ажиллагаанд хосын охин, жүжигчин Кейт Хадсон болон түүний дотны найз, жүжигчин Риз Уизерспун оролцжээ. Нэг өдөр “Алдарын од”-той болж буй хос хэвлэлийнхэнд “Үнэхээр гайхалтай байна. Итгэхийн аргагүй юм. “Алдарын од”-той болохыг их эртнээс мөрөөддөг байлаа. Бидний мөрөөдөл минь өнөөдөр биелсэнд талархаж байна” гэжярьжээ.

FOOTBALL NEWS

### Буффон Аваргуудын лигийн 100 дахь тоглолтдоо оролцлоо

Аваргуудын лигийн хагас шигшээ шатан Италийн “Ювентус” клуб Францын “Монако”-гийн талбайд зочилж тоглохоод Турины багийн хаалгач Жанлуижи Буффон гараанд гарсан. Ингэснээр өдгөө 39 настай хаалгач “Ювентус”-ын төлөө Аваргуудын лигийн 100 дахь тоглолтдоо оролцлоо. Мөн тэрбээр энэ амжилтад хүрсэн “Ювентус”-ын анхны тоглогч болж байгаа юм. Тэгвэл Аваргуудын лигт хамгийн олон тоглолтод оролцсон амжилтыг “Реал”-ын домогт хаалгач, одоо “Порто”-д тоглож буй Икер Касильяс эзэмшдэг. Тэрбээр 164 тоглолтод оролцсон юм.



### Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд

**Мерси Урнаа**

Би зүүдэндээ их юм ярьдаг юм аа. Нэг орой хадмынд хөдөөний хүмүүс ирээд, хадам аав ээжтэйгээ нэг өрөөнд хоносон юм. Тэгээд унтаж байхдаа “Хайр аа танай ээж яагаад ийм шуналтай юм бэ” гээд л асуугаад байсан гэсэн . Тэрийг нь сонссон хадам ээж шөнө унтаж чадахгүй уур нь хүрсэн бололтой миний өгсөн жижиг сажиг бэлэгнүүдийг бүгдийг нь миний хажууд тавьчихаад унтаад өгсөн гэсэн. Би юу ч мэдээгүй унтаад л байсан байх нь... Уучлаарай.


